# НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
# 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР 2023 ОН

# АГУУЛГА


НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд гүйцэтгэсэн ажлын явц, үр дүн.............................................. 1

1.2. Улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл (он дамжсан, шинээр дүүргээр ажлын төрлөөр, салбарын эх үүсвэрээр)..........................................1-5

1.3. Нийслэлийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан тухайн байгууллагаас хийж гүйцэтгэх ажлын хэрэгжилт үр дүнтэй холбоотой мэдээлэл..........................................................................................5

1.4. Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл ..........................................................................5

1.5. Нийслэлийн Засаг даргын эрх шилжсэн захирамжийн хэрэгжилтийн мэдээлэл.........................................................................................5-7

ХОЁРДУГААР БҮЛЭГ.ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН

2.1. Монгол Улсын Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Нийслэлийн засаг даргын албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлээс өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл..........................................................................................7

2.2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт ...................................................7

ГУРАВДУГААР БҮЛЭГ.БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

3.1. Газрын даргын Нийслэлийн Засаг даргатай байгуулсан хариуцлагын гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт ..............................................8

3.2. Дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн мэдээлэл ...................................8

3.3. Хүний нөөцийг чадавхжуулах тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын хэрэгжилтийн мэдээлэл ............................................................................8-9

3.4. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл. (Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажилллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 4 дүгээр хавсралтаар баталсан аргачлалыг баримтална)..............9-15

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

4.1. Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл (Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажилллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9 дүгээр хавсралтаар баталсан аргачлалыг баримтална)...........................................16-19

4.2. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал...............................................20

4.3. Төсөв санхүүгийн ил тод байдал ..........................................................20-21

4.4. Санхүүгийн тайлан мэдээний чиглэлээр ..................................................21-23

ТАВДУГААР БҮЛЭГ.БУСАД МЭДЭЭЛЭЛ

5.1. Дотоод ажлын чиглэлээр (зохион байгуулсан ажил, хурал, техникийн зөвлөлийн хурал)...........................................................................................23-30

5.2. Сургалтын чиглэлээр ...........................................................................31

5.3. Гэрээ эрх зүйн чиглэлээр .......................................................................31-33

5.4. Архивын чиглэлээр .............................................................................33-34

5.5. Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах чиглэлээр ................35-46
5.6. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, судалгааны чиглэлээр ................................46-51
5.7. Хяналт шинжилгээ, үнэлгээний хорооны ажлын мэдээлэл ............................ 51

ДҮГНЭЛТ
ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

## 1.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд гүйцэтгэсэн ажлын явц, үр дүн

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс манай газрын хариуцан хэрэгжүүлэх ажлын биелэлтийг хагас жилийн байдлаар 8 зорилт 22 ажлын хүрээнд 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 4/2153 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.

*Хүснэгт 1.1.-1 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт*

| Ангилал | 2022 оны хагас жилийн байдлаар | 2023 оны хагас жилийн байдлаар |
|---|---|---|
| Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт | 2022.03.25-ны 4/1045<br>13 ажил | 2023.03.25-ны (цахим)<br>22 ажил |
| | 2022.06.03-ны 4/2043<br>13 ажил | 2023.06.15-ны 4/2153<br>22 ажил |

## 1.2. Улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл (он дамжсан, шинээр дүүргээр ажлын төрлөөр, салбарын эх үүсвэрээр)

*Зураг төслийн ажлын хүрээнд:* Улс болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 оны хагас жилийн байдлаар зөвлөх үйлчилгээний он дамжин хэрэгжиж буй 22, шинээр ирсэн 8, нийт 30 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна.

*Хүснэгт 1.2.-1. Улс болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх зураг төсвийн ажил*

| Хэрэгжиж эхэлсэн он | Ажлын тоо | Гэрээний дүн (төгрөг) | Явц (хувь) | Санхүүжилтийн дүн (төгрөг) | Санхүүжилт (хувь) |
|---|---|---|---|---|---|
| 2022-2023 | 22 | 4,815,723,874.0 | 69% | 1,063,755,338.0 | 26% |
| **Нийт** | **22** | **4,815,723,874.0** | **69%** | **1,063,755,338.0** | **26%** |

2023 онд шинээр ирсэн зөвлөх үйлчилгээний 8 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулагдан хэрэгжиж байна.

*Хүснэгт 1.2.-2. Зөвлөх үйлчилгээний 8 төсөл, арга хэмжээ*

| Хэрэгжиж эхэлсэн он | Ажлын тоо | Гэрээний дүн (төгрөг) | Явц (хувь) | Санхүүжилтийн дүн (төгрөг) | Санхүүжилт (хувь) |
|---|---|---|---|---|---|
| 2023 он | 8 | 1,021,417,823.0 | 54% | 71,938,702.0 | 13% |
| **Нийт** | **8** | **1,021,417,823.0** | **54%** | **71,938,702.0** | **13%** |

Нийт ажлыг хөрөнгийн эх үүсвэрээр ангилбал:

*Хүснэгт 1.2.-3. Хөрөнгийн эх үүсвэрээр ангилбал:*

| Эх үүсвэр | Ажлын тоо | Төсөвт өртөг (сая.төгрөг) | Гэрээний дүн (төгрөг) | Явц (хувь) |
|---|---|---|---|---|
| НТХО | 17 | 2 997,5 | 2,893,819,195 | 60% |
| НОНХС | 4 | 637,4 | 571,162,902 | 86% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| ДОНХС | 4 | 572,9 | 547,852,300 | 71% |
| УТХО | 1 | 500,0 | 484,000,000 | 70% |
| Бусад | 4 | 1 350,0 | 1,340,307,300.0 | 55% |
| **Нийт** | **30** | **6 041,8** | **5,837,141,697.0** | **65%** |

2023 онд гэрээ байгуулсан барилга угсралт, тохижилт, засвар шинэчлэлийн 152 ажлын зураг төсөлд хяналт тавьж, зөвлөмж арга зүйгээр хангаж ажиллаж байна.

*Хүснэгт 1.2.-4. 2023 оны зураг төслийн шинээр хэрэгжиж буй ажлууд*

| д/д | Зургийн ажлын үе шатанд | Ажлын тоо |
|---|---|---|
| 1 | Загвар зураг боловсруулж байна | 5 |
| 2 | Захирамжид өөрчлөлт орсон | 1 |
| 3 | Техникийн нөхцөл хүссэн | 1 |
| 4 | Ажлын зураг төсөв боловсруулж байна | 47 |
| 5 | Мэргэжлийн байгууллага хянаж байна. | 14 |
| 6 | Магадлалд хүргүүлсэн | 16 |
| 7 | Газаргүй | 3 |
| 8 | Хүлээлгэн өгсөн | 61 |
| 9 | Судалгаа хийгдэж байгаа | 4 |
| **Нийт** | | **152** |




*График №1.2-1*

*Захиалагчийн хяналт тавих ажлын хүрээнд:* 2023 оны хагас жилийн байдлаар манай газарт нийт барилга угсралт, их засварын 1,174 их наяд төгрөгийн гэрээний дүнтэй 576 ажил 54 хувийн дундаж гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Үүнээс 2022-2023 онд дамжин хэрэгжих 1,2 их наяд төгрөгийн гэрээний дүнтэй 474 төсөл, арга хэмжээний дундаж хэрэгжилт 60 хувь, 2023 онд шинээр гэрээ байгуулсан 145.1 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 102 төсөл, арга хэмжээ 27 хувийн дундаж явцтай хэрэгжиж байна.

*Хүснэгт 1.2.-5. 2023 оны нийт ажил:*

| Ангилал | Ажлын тоо | Гэрээний дүн (төгрөг) | Ажлын явц (хувь) |
|---|---|---|---|
| Он дамжсан | 474 | 1,225,580,251,607 | 60% |
| 2023 оны ажил | 102 | 145,137,075,338 | 27% |
| **Нийт** | **576** | **1,370,717,326,945** | **54%** |

*Хүснэгт 1.2.-6. 2023 онд шинээр хэрэгжиж байгаа ажлын мэдээлэл, эх үүсвэрээр:*

| Эх үүсвэр | 2023 онд шинээр ирсэн гэрээний ажил | | |
|---|---|---|---|
| | Ажлын тоо | Гэрээний дүн (төгрөг) | Ажлын явц (хувь) |
| УТХО | 11 | 74,294,118,813 | 9% |
| НТХО | 15 | 22,314,017,048 | 22% |
| НОНХС | 34 | 5,952,764,489 | 36% |
| ДОНХС | 6 | 2,497,046,040 | 5% |
| ДХ, бусад | 36 | 40,079,128,948 | 29% |
| **Нийт** | **102** | **145,137,075,338** | **27%** |

*Хүснэгт 1.2.-7. 2023 онд шинээр хэрэгжиж байгаа ажлын мэдээлэл, төрлөөр:*

| Товч төрөл | 2023 онд шинээр хэрэгжиж буй ажил | | |
|---|---|---|---|
| | Ажлын тоо | Гэрээний дүн (төгрөг) | Ажлын явц (хувь) |
| Сургуулийн барилга, өргөтгөл | 3 | 21,479,186,567 | 47% |
| Цэцэрлэгийн барилга, өргөтгөл | 6 | 17,501,532,354 | 56% |
| Бусад барилга байгууламж | 4 | 49,246,019,904 | 19% |
| Инженерийн шугам сүлжээ | 12 | 16,837,088,425 | 17% |
| Их засвар | 11 | 15,835,476,283 | 26% |
| Тохижилт | 46 | 15,897,660,181 | 28% |
| Гэрэлтүүлэг, камержуулалт | 2 | 108,052,964 | 6% |
| **Нийт** | **102** | **145,137,075,338** | **27%** |

*Хүснэгт 1.2.-8. Он дамжин хэрэгжиж байгаа ажлын мэдээлэл, төрлөөр:*

| Товч төрөл | 2022-2023 онд дамжин хэрэгжих ажил | | |
|---|---|---|---|
| | Ажлын тоо | Гэрээний дүн (төгрөг) | Ажлын явц (хувь) |
| Сургуулийн барилга, өргөтгөл | 24 | 200,176,605,048 | 37% |
| Цэцэрлэгийн барилга, өргөтгөл | 61 | 149,774,282,353 | 46% |
| Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор | 17 | 80,603,581,134 | 26% |
| Спорт заал, цогцолбор | 4 | 36,826,393,550 | 65% |
| Хорооны цогцолбор, өргөтгөл | 11 | 22,089,496,187 | 51% |
| Бусад барилга байгууламж | 51 | 300,156,124,893 | 54% |
| Инженерийн шугам сүлжээ | 75 | 233,822,518,441 | 59% |
| Гэр хорооллын дахин төлөвлөлт | 75 | 233,822,518,441 | 59% |
| Их засвар | 76 | 39,142,740,338 | 79% |
| Тохижилт | 113 | 84,697,289,380 | 68% |
| Гэрэлтүүлэг, камержуулалт | 16 | 6,209,893,047 | 78% |
| **Нийт** | **474** | **1,225,580,251,607** | **60%** |

2022 онд Нийслэлд хувийн хэвшлийн хөрөнгөнөөс бусад эх үүсвэрээр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний мэдээллийн сан нэгтгэн боловсруулж, хэрэгжилтийг гаргах, хөрөнгө оруулалтын ажлуудын уялдаа холбоог сайжруулж мэдээллээр хангах зорилготойгоор Нийслэлд 2022 онд хэрэгжсэн УТХО, НТХО, НОНХС, ДОНХС, ДХ, Ашиглагч байгууллагуудын өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 781.7 тэрбум төгрөгийн 1134 төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлийг 35 нарийвчилсан үзүүлэлтээр нэгтгэн боловсруулсан. Үүнээс Манай газар хяналт тавин хэрэгжүүлсэн 756, яам, агентлаг бусад газраар хяналт тавин хэрэгжүүлсэн 378 төсөл, арга хэмжээ байна.

*Хүснэгт 1.2.-9. 2022 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл (дүүргээр)*

| № | Дүүрэг | Ажлын тоо | 2022 онд санхүүжих дүн (сая.төгрөг) |
|---|---|---|---|
| 1 | Сонгинохайрхан | 220 | 159,635.8 |
| 2 | Баянзүрх | 282 | 203,069.8 |
| 3 | Чингэлтэй | 123 | 122,927.3 |
| 4 | Хан-Уул | 151 | 151,239.5 |
| 5 | Сүхбаатар | 164 | 87,789.5 |
| 6 | Багануур | 25 | 12,920.2 |
| 7 | Налайх | 45 | 10,854.9 |
| 8 | Баянгол | 102 | 31,826.5 |
| 9 | Багахангай | 22 | 1,465.1 |
| **Нийт** | | **1134** | **781,728.6** |

Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 2023 онд төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлын мэдээллийн сан үүсгэх, явцын мэдээлэл шинэчлэх, удирдлагуудыг мэдээллээр хангах ажлын хүрээнд:

- Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 2023 онд улсын төсөв, нийслэлийн төсөв, нийслэл, дүүргийн орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсвийн хөрөнгөөр шинээр хэрэгжих нийт 723 ажлын мэдээллийн санг 36 үзүүлэлтээр үүсгэсэн.
- Нийслэлийн 9 дүүрэгт нийт 2023 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ажлаас манай газар захиалагчийн хяналт тавих барилга угсралт, их засварын 95 ажил, зураг төсвийн 10 ажил хэрэгжиж байна.
- 2023 онд шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлын явцын мэдээллийг тайлант хугацаанд Төрийн худалдан авах ажиллагааны нэгдсэн систем болон газрын барилга угсралт, их засвар, зураг төсвийн мэдээ хэсэгт тус тус 20 удаа шинэчлэсэн байна.

**2023 онд шинэ болон шилжих хөрөнгө оруулалтын ажил:**

*Хүснэгт 1.2.-10. 2023 онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэл (дүүргээр)*

| № | Дүүрэг | Ажлын тоо | 2023 онд санхүүжих дүн (сая.төгрөг) |
|---|---|---|---|
| 1 | Сонгинохайрхан | 144 | 81,061.2 |
| 2 | Баянзүрх | 210 | 148,383.0 |
| 3 | Чингэлтэй | 67 | 59,822.0 |
| 4 | Хан-Уул | 91 | 151,239.5 |
| 5 | Сүхбаатар | 74 | 34,245.5 |
| 6 | Багануур | 12 | 12,920.2 |
| 7 | Налайх | 40 | 10,854.9 |
| 8 | Баянгол | 119 | 97,661.9 |
| 9 | Багахангай | 12 | 1,465.1 |
| **НИЙТ** | | **723** | **597,653.3** |

2022, 2023 онд Нийслэлд хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ (Ажлын тоо, төсөвт өртгөөр)







*График №1.2-2*

- Улсын төсөв, нийслэлийн төсөв, нийслэл, дүүргийн орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022-2023 онд он дамжин манай газраар хэрэгжих барилга угсралт, их засвар, зураг төсвийн 474 ажлын мэдээллийг 36 үзүүлэлтээр тогтмол шинэчилсэн.

- 2022-2023 онд он дамжин хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын барилга угсралт, их засварын 474, зураг төсвийн 22 ажил байна. Хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажлууд нь дунджаар 56 хувийн гүйцэтгэлтэй байна.

- Тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын мэдээллийн санг 20 удаа шинэчлэсэн.

*Хүснэгт 1.2.-11. 2022-2023 онд он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэл (дүүргээр)*

| № | Дүүрэг | Ажлын тоо | 2023 онд санхүүжих дүн (сая.төгрөг) | Гэрээний дүн (төгрөг) |
|---|---|---|---|---|
| 1 | Сонгинохайрхан | 103 | 86,204.7 | 212,721,867,509.0 |
| 2 | Баянгол | 47 | 28,459.2 | 144,338,276,939.0 |
| 3 | Хан-Уул | 65 | 30,998.0 | 266,846,214,823.0 |
| 4 | Чингэлтэй | 27 | 29,083.5 | 59,882,891,336.0 |
| 5 | Сүхбаатар | 42 | 33,678.2 | 114,319,689,214.0 |
| 6 | Баянзүрх | 138 | 31,065.4 | 212,627,128,716.0 |
| 7 | Багануур | 14 | 7,387.3 | 31,058,788,437.0 |
| 8 | Багахангай | 6 | 500.0 | 5,571,405,499.0 |
| 9 | Налайх | 21 | 11,113.7 | 88,602,799,627.0 |
| 10 | Дүүрэг дамнасан | 11 | 2,510.6 | 21,980,725,378.0 |
| **НИЙТ** | | **474** | **261,000.6** | **1,179,669,583,704.0** |

## 1.3. Нийслэлийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан тухайн байгууллагаас хийж гүйцэтгэх ажлын хэрэгжилт үр дүнтэй холбоотой мэдээлэл

Нийслэлийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн А/1106 дугаар Журам шинэчлэн батлах тухай захирамжийн дагуу “Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван үндсэн чиглэл”-д тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн биелэлтээс манай газрын чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх 2 зорилгын 3 ажлын биелэлтийг 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4/97 тоот албан бичгээр хүргүүлсэн.

## 1.4. Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл

Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний биелэлтийг https://erp.ulaanbaatar.mn сайтын Хяналт шинжилгээ, үнэлгээний программд хагас жилийн байдлаар 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр тайлагнасан.

## 1.5. Нийслэлийн Засаг даргын эрх шилжсэн захирамжийн хэрэгжилтийн мэдээлэл

Манай газарт эрх шилжсэн Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст 2023 оны 01 дүгээр улирал, хагас жилийн байдлаар Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсийн Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт, үр дүнд хийх хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэнд ERP цахим хаягаар хүргүүлсэн.

*Хүснэгт 1.5.-1 Манай газарт эрх шилжсэн Нийслэлийн Засаг даргын Захирамжийн биелэлт*

| Ангилал | 2022 оны байдлаар | 2023 оны байдлаар |
|---|---|---|
| Нийслэлийн Засаг даргын Захирамжийн биелэлт 2023 оны 01 дүгээр улирлын байдлаар | 233 ажил<br>Дундаж биелэлт 45% | 152 ажил<br>Дундаж биелэлт 35% |
| Нийслэлийн Засаг даргын Захирамжийн биелэлт 2023 оны хагас жилийн байдлаар | 328 ажил<br>Дундаж биелэлт 23% | 212 ажил<br>Дундаж биелэлт 42% |

Нийслэлийн Засаг даргын захирамжаар 2023 онд захиалагчийн хяналт хийх төсөл, арга хэмжээний ажлын хэрэгжилт, үр дүн (ажлын төрлөөр, эх үүсвэрээр):

Нийслэлийн Засаг даргын 2023 оны захирамжаар захиалагчийн хяналт хийхийг даалгасан 88 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны бэлтгэлийг хангаж ажилласан. Эдгээрээс 66 төсөл, арга хэмжээний бэлтгэл бүрэн хангагдсан байна. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор 10 төсөл, арга хэмжээ хүчингүй болсон байна. Газаргүй, байршил тодорхойлох 1 төсөл, арга хэмжээ, дүрмээр хүлээсэн үүргээр бусад байгууллагад шилжсэн 4, захирамж өөрчлүүлэх 3 төсөл, арга хэмжээ, 4 төсөл, арга хэмжээний даалгавар боловсруулж байна. Захирамжаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний биелэлтийн явц 93,6 хувьтай байна.

2023 онд нийт гэрээ байгуулсан барилга угсралт, тохижилт, засвар шинэчлэлийн 152 ажлын зураг, төсөлд хяналт хийж зөвлөмж арга зүйгээр ханган ажиллаж байна.

*Хүснэгт 1.5.-2 2023 онд Нийслэлийн Засаг даргын захирамжаар захиалагчийн хяналт хийхийг даалгасан төсөл арга хэмжээнүүдийг ангилан авч үзвэл:*

| д/д | Худалдан авах ажиллагааны хүрээнд | Ажлын тоо |
|---|---|---|
| 1 | Хүргүүлсэн | 24 |
| 2 | Тендер зарлагдсан | 1 |
| 3 | Тендер нээсэн | 2 |
| 4 | Боловсруулж байна | 4 |
| 5 | Дүрмээр хүлээсэн үүргээр гүйцэтгэх | 4 |
| 6 | Гэрээ байгуулагдсан | 28 |
| 7 | Зөвлөмж ирсэн | 11 |
| 8 | Захирамж өөрчлүүлэх | 3 |
| 9 | Хүчингүй болсон | 10 |
| 10 | НИТХ-ын тогтоолд өөрчлөлт орсон | 1 |
| | Нийт | 88 |




*График 1.5.-1.*

*Зураг төслийн даалгавар боловсруулах, техникийн тодорхойлолт батлуулах үйл ажиллагааны хүрээнд:*

2023 оны хагас жилд нийт 47 төсөл, арга хэмжээний ажлын зургийн даалгаврыг боловсруулан худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар хүргүүлсэн. Дээрх даалгавар боловсруулах, батлуулах үйл ажиллагааг өнгөрсөн онуудын мөн үетэй харьцуулбал:




*График 1.5.-2.*

## ХОЁРДУГААР БҮЛЭГ.ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН

### 2.1. Монгол Улсын Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Нийслэлийн засаг даргын албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлээс өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн мэдээг 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийх хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан Ахлах мэргэжилтэнд ERP цахим хаягаар хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 49 дүгээр "2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай" тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан ажиллав. Холбогдох тайланг 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 2/1151 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлан хүргүүлсэн.

### 2.2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хагас жилийн байдлаар гаргасан. Нийт 6 зорилтын хүрээнд 30 ажлын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 4/2062 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.

*Хүснэгт 2.2.-1 Хүргүүлсэн биелэлт*

| Ангилал | 2021 оны хагас жилийн байдлаар | 2022 оны хагас жилийн байдлаар |
|---|---|---|
| Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 2022.03.25 –ны 4/1046<br>10 ажил | - |
| Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 2022.06.03 –ны 4/2056<br>10 ажил | 2023.06.08 4/2062<br>30 ажил |

## ГУРАВДУГААР БҮЛЭГ.БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

### 3.1. Газрын даргын Нийслэлийн Засаг даргатай байгуулсан хариуцлагын гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан 4 дүгээр хавсралтын дагуу газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, хариуцлагын гэрээний хамт 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 5/10 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаар батлуулан биелэлтийг ханган ажиллаж байна.

Мөн 7 дугаар хавсралтаар батлагдсан загварын дагуу газрын 2023 оны 01 дүгээр улирлын гүйцэтгэлийн тайланг 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 5/1339,

Хагас жилийн гүйцэтгэлийн тайланг 2023 оны 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 5/2273 тоот албан бичгээр тус тус Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Биелэлт 2022 оны мөн үед 84 хувьтай байсан бол 2023 онд 99 хувьтай байна.

### 3.2. Дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн мэдээлэл

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 26 дугаар тогтоолоор батлагдсан газрын дүрмээр хүлээсэн үүргийн биелэлтийг хагас жилийн байдлаар 97.2 хувьтай хэрэгжсэн бөгөөд Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 5/2146 тоот албан бичгээр хүргүүлсэн.

### 3.3.Хүний нөөцийг чадавхжуулах тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын хэрэгжилтийн мэдээлэл

2023 оны хагас жилийн байдлаар (үндсэн 84, гэрээт 3) нийт 87 ажилтан, албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. 9 ажилтан урт хугацааны, 4 ажилтан хүүхэд асрах чөлөөтэй.

Хүний нөөцийн дор дурдсан шилжилт хөдөлгөөн хийгдсэн байна. Үүнд:

Шинээр томилогдсон 4, албан тушаал өөрчлөгдсөн 3, үндсэн ажилтнаар томилогдсон 2, ажлаас чөлөөлөгдсөн 3 ажилтан байна.




*График 3.3.-1.*

***Газрын даргын тушаал:***

Газрын даргын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гарсан 52, газрын боловсон хүчний чиглэлээр гарсан 66, нийт 118 тушаал батлагдсан байна.

***Дүрэм журам шинэчлэн боловсруулсан өөрчлөн шинэчлэсэн тухай:***

Дараах дүрэм, журмуудыг шинэчлэн батлав. Үүнд:

- Газрын даргын А/08 дугаар тушаалаар Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүн, ажиллах журам,
- А/22 дугаар тушаалаар Архивын дүрэм,

- А/47 дугаар тушаалаар хөдөлмөрийн дотоод журам,
- А/48 дугаар тушаалаар Албан хэрэг хөтлөлтийн журам,
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журам,

Техникийн зөвлөлийн ажиллах журам, Захиалагчийн техник хяналтын журам, Иргэдтэй хийх уулзалтыг зохион байгуулах журам, Байгууллагын нууцын журамд өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Мөн сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах журмын төсөл боловсруулан ажиллаж байна. Ажлын явц 40 хувьтай.




*График 3.3.-2.*

*Шагнал урамшуулал, сахилгын шийтгэл:*

Сар шинийн баяр "Цагаан сар"-ыг тохиолдуулан ажлын амжилтаараа хамт олноо манлайлан ажиллаж буй ажилтнуудыг шагналд тодорхойлон "Алтан гадас" одонгоор 1, "Хөдөлмөрийн" хүндэт" медалиар 2 ажилтан тус тус шагнагдан хүндэтгэл үзүүлэв.

Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан ажлын амжилтаараа хамт олноо манлайлсан, Нийслэл хотын бүтээн байгуулалтын салбарт үр бүтээлтэй, ажиллаж буй албан хаагчдыг шагнуулахаар төрийн одон медальд 10, яам 1, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, 11, Нийслэлийн Засаг даргын шагналд 17 албан хаагчийг тодорхойлов.Төрийн одон медальд тодорхойлсон шагналын тодорхойлолтыг 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 5/2190,5/2191, Нийслэлийн Засаг даргын шагналын тодорхойлолтыг 5/2192, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шагналын тодорхойлолтыг 5/2188 тоот албан бичгээр болон цаасан эх хувиар Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Эрчим хүчний яаманд тус тус хүргүүлэв.

Зураг төслийн хэлтсийн дарга Баатаржавын Лхагважав, Мэдээллийн технологийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Сүхбатын Соёмбо нар нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн ажил тасалж хариуцлага алдсан тул сануулах сахилгын шийтгэлийг газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн Б/55 дугаар тушаалаар баталгаажуулан, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллав.

**3.4. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажилллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 4 дүгээр хавсралтаар баталсан аргачлалыг баримтална:**

Засгийн газрын 2020 оны 206 дугаар
тогтоолын 4 дүгээр хавсралт

**"НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ**
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

| № | Үйл ажиллагаа | № | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|
| Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх | | | | | | |
| 1. | Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт | 1.1. | Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо: | 5-аас дээш | 50 сургалт (100 хувь) | Хамрагдсан сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэг:<br>1. "Хотын стандарт" төслийн хэлэлцүүлэг-6<br>2. "2022 оны Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг мэдүүлэхэд анхаарах зүйл" сургалт-1<br>3. Барилга, байгууламжийн угсралт, засварын ажлын төсөв зохиох " Анхан шат"-ны сургалт (Гэрчилгээ)-1<br>4. Бодлогын баримт бичиг боловсруулах арга зүй (Төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналт, хяналт үнэлгээ)-2<br>5. Мэдээллийн цаг зохион байгуулсан тухай-7<br>6. "Төслийн менежмент ба үйл ажиллагаа" семинар (Франц улс)-1<br>7. Бодлогын баримт бичиг боловсруулах арга зүй - удирдах ажилтны сургалт-1<br>8. Архив, албан хэрэг хөтлөлтийн шинээр мөрдөгдөж байгаа хууль, журмын танилцуулга сургалт-54<br>9. "Цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх нь" сургалт-2<br>10. "Алсын хараа 2050" хүрээнд "Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь" сургалт-1<br>11. "ERP системийн хэрэглээ" сургалт-1<br>12. "2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад анхаарах зүйл" цахим сургалт-1<br>13. "Ес зүйн зөвлөлийн үйл ажиллагааны эрх зүйн орчин" цахим сургалт-1 |
| | | Үүнээс | Ажлын байран дахь сургалт | - | 4 | |
| | | | Мэргэшүүлэх сургалт | - | 32 | |
| | | | Туршлага солилцох арга хэмжээ | - | 4 | |
| | | | Бусад | - | 8 | |
| | | 1.2. | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: | 87 | 404 (Давхардсан тоогоор) | |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | 43 | 233 (Давхардсан тоогоор) | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Эрэгтэй албан хаагч | 44 | 161 (Давхардсан тоогоор) | 14."Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам" сургалт-2<br>15."Төрийн архивт нөхөн баяжилт хийх ажлын арга зүй" сургалт-1<br>16.Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалт (АЗ)-22<br>17."Байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй" сургалт-1<br>18.Газар хөдлөлтийн гамшгийн аюулыг таниулах сургалт-1<br>19."Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтан бэлтгэх" цахим сургалт (Сертификат)-1<br>20.Төсөвчний анхан шатны мэдлэг олгох сургалт (Сертификат)-2<br>21."Барилгын чанар, аюулгүй байдал, стандарт" зөвлөгөөн-5<br>22."Эрх зүйн орчны шинэчлэл", "Төрөөс стандартчилал, хэмжил зүйн талаар баримтлах бодлого", "Стандарт ба хөгжил" үндэсний хөтөлбөрийн төслийн хэлэлцүүлэг-3<br>23.БНХАУ-ын Бээжин хот "Олон улсын ханын өнгөлгөө болон орон байрны тохижилт"-ын үзэсгэлэн-4<br>24.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын системийн нэвтрүүлэлтийг хэрэгжүүлэх чадавх бэхжүүлэх сургалт-2<br>25.БНХАУ-ын Шанхай хот "China Refrigeration 2023" үзэсгэлэн-1<br>26.БНХАУ-ын Гуанжоу хот "Canton fair 2023" үзэсгэлэн-2<br>27."Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангах, тохиолдсон үед авах арга хэмжээ" сургалт-62<br>28.Тогтвортой хөгжил, хүрээлэн буй орчны инженерчлэл сургалт-7<br>29."Улаанбаатар олон улсын хөрөнгө оруулалт, түншлэлийн форум-2023" зөвлөгөөн-6<br>30."eDOC системийн хэрэглээ" сургалт-1<br>31."Хууль, эрх зүй" сургалт-2<br>32.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын системийн нэвтрүүлэлтийг хэрэгжүүлэх чадавх бэхжүүлэх сургалт-8<br>33.Хяналт-шинжилгээ үнэлгээний нэгдсэн тайлангийн дэд системд тайлагнах сургалт-2<br>34.Төслийн удирдлагын үндэс сургалт-1<br>35.Төрийн албаны шинэтгэлийн зарчим, бодлого, Төрийн албаны ёс зүйн тухай хуулийн төсөл болон МУ-ын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн уулзалт, хэлэлцүүлэг-10<br>36.Стресс менежмент сургалт-2 |
| | | | Удирдах албан тушаалтан | 9 | 10 (Давхардсан тоогоор) | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | 78 | 81 (Давхардсан тоогоор) | |
| | | 1.3. | Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь | 85-аас дээш | 100 хувь | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 37."Цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх нь" цахим сургалт-4<br>38.Төрийн байгууллагад нийтлэг хөтлөгддөг баримт бичиг боловсруулах арга зүй-2<br>39.Төрийн албан хаагчийн ёс зүй-6<br>40.Авлигын эсрэг анхан шатны цахим сургалт-23<br>41.Бизнес процессын дахин загварчлал сургалт-1<br>42."Баримт нягтлан шалгах арга зүйн комисс" төлөвлөгөө хэлэлцэх хурал-1<br>43."Засгийн газрын худалдан авах ажиллагааны удирдлага, зохион байгуулалт", "Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааны тухай", "Цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээллэх журам" сургалт-27<br>44.Эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан цахим сургалт-1<br>45.Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй сургалт-1<br>46.“Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх нь” сургалт-53<br>47.Улс, орон нутаг, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний барилга байгууламж, дэд бүтэц, хот тохижилтын ажлын салбарын мэдээллийг ил тод, нээлттэй болгох стандартын асуудлыг хэлэлцүүлэх-4<br>48."ERP системийн хэрэглээ" цахим сургалт-2<br>49.Чанарын менежментийн тогтолцоо, шаардлага ISO 9001 стандартын танилцуулга сургалт-42<br>50.Төслийн удирдлагын үндэс-10<br>2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар хувь хүнийг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр 50 сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 404 албан хаагч хамрагдав. Үүнд:<br>- Гадаад томилолт, семинар-4 удаа, 8 албан хаагч<br>- Дотоод сургалт-4 удаа, 164 албан хаагч<br>- Зөвлөгөөн, семинар, хэлэлцүүлэг-6 удаа, 31 албан хаагч<br>- Хувь хүний хөгжлийн сургалт-4 удаа, 8 албан хаагч<br>- Мэргэшүүлэх сургалт-32 удаа, 193 албан хаагч тус тус хамрагдав. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2. | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт | 2.1. | Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо | - | 4 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2023 оны 01 дүгээр сарын 15-22-ны өдрүүдэд Франц улсад зохион байгуулагдсан "Төслийн менежмент ба үйл ажиллагаа" сургалт, семинарт газрын дарга Б.Мөнхбат оролцов.<br>БНХАУ-ын Бээжин хотод 2023 оны 03 дугаар сарын 17-24-ний өдрүүд зохион байгуулагдсан "Олон улсын ханын өнгөлгөө болон орон байрны тохижилт" үзэсгэлэнд Барилга захиалагчийн хэлтсийн бусийн Ахлах инженер Б.Намсрайжав, Цахилгааны хяналтын инженер Э.Оргил, Дулаан хангамж, агаар сэлгэлтийн инженер Х.Наранцэцэг, Зураг төслийн хэлтсийн Зураг төслийн хяналтын инженер Б.Бат-Оргил нар оролцож, орчин үеийн шинэ техник технологи, шинээр нэвтрүүлж, үйлдвэрлэж байгаа барилгын материалын үзэсгэлэн худалдаатай танилцав.<br>БНХАУ-ын Шанхай хотод 2023 оны 04 дүгээр сарын 04-12-ны өдрүүд зохион байгуулагдсан "China Refrigeration 2023" үзэсгэлэнд Барилга захиалагчийн хэлтсийн бусийн Ахлах инженер Н.Энхбаяр оролцож, хэрэглэгт, халаалт, агааржуулалтын салбарын тоног төхөөрөмж, шинэ дэвшилтэт технологитой танилцав.<br>БНХАУ-ын Гуанжоу хотод 2023 оны 04 дүгээр сарын 13-21-ний өдрүүд зохион байгуулагдсан "Canton fair 2023" үзэсгэлэнд Барилга захиалагчийн хэлтсийн бусийн Ахлах инженер С.Баасансүрэн, Барилгын хяналтын инженер Ч.Баярхүү нар оролцов. |
| | | 2.2. | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: | - | 8 | |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | - | 1 | |
| | | | Эрэгтэй албан хаагч | - | 7 | |
| | | | Удирдах албан тушаалтан | - | 1 | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | - | 7 | |
| | | 2.3. | Гадаад сургалтад хамруулсан байдал:<br>Нийт албан хаагчдад эзлэх хувь | 20-оос дээш | 9 хувь | |
| 3. | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн | 3.1. | Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг) | 100 хувь | 100 хувь | Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалт (АЗ)-д 2.125.000 төгрөг, "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан бэлтгэх сургалт" 285.000 төгрөг тус тус зарцуулав. |
| | | 3.2. | Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь | 15-аас доош | 100 хувь | Шинээр томилогдсон 4, ажил, албан тушаал өөрчлөгдсөн 3, үндсэн ажилтнаар томилогдсон 2, ажлаас чөлөөлөгдсөн 3, шүүхийн шийдвэрийн үндсэн дээр урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд томилогдсон 1, удаан хугацааны чөлөөгөө дуусган, өмнө эрхэлж байсан ажил, албан тушаалд эргүүлэн томилсон 1, Авлигатай тэмцэх газрын Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай албан бичгийг үндэслэн түр орлон гүйцэтгэгчээр ажилд томилсон 1, хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа 4 ажилтан байна. |
| Хэсгийн дундаж – 100 хувь | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах** | | | | | | |
| 4. | Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх | 4.1. | Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь | 100 хувь | 100 хувь | Албан хаагчдын ажилласан жил, мэргэшсэн зэргийн нэмэгдлийг 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталж 1,265,081,144.88 олгосон. |
| | | 4.2. | Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг) | 100 хувь | 100 хувь | Нийт ажилтнуудад ажлын хоногт 122,040,000.00 төгрөг олгосон. |
| 5. | Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх | 5.1. | Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж) | 80-аас дээш | 50 хувь | Газрын ажилтнуудаас "Ажлын байрны сэтгэл ханамжийн судалгаа"-г google.doc form ашиглан 2023 оны 06 дугаар 02-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрүүдэд 12 асуулга бэлтгэн цахим хэлбэрээр авч, судалгааны үр дүнг гаргаж тайланг нэгтгэсэн. Тус судалгаанд 40 албан хаагч оролцож, 48 хувийн хамрагдалттай байв.<br>Судалгаанд үндэслэн албан хаагчдын цалин урамшуулал, нийгмийн баталгаа, сургалт хөгжил, эрүүл мэнд, шууд удирдах албан тушаалтны хандлага, хэлтэс хоорондын уялдаа холбоо, хамт олны уур амьсгал зэрэг асуудлыг бодитоор үнэлж дүгнэсэн ба цаашид сайжруулвал зохих ажилд анхааран ажиллаж байна. |
| 6. | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх | 6.1. | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд) | 1-ээс дээш | 100 хувь | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаал, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 06 дугаар тогтоолын хүрээнд халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах ажил 2023 онд үргэлжлэн орон даяар явагдаж байгаатай холбогдуулан ажилтнуудыг өөрийн харьяа дүүргийн эмнэлгээр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамрагдах талаар мэдээлэл өгч ажиллаж байна.<br>Газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн Б/28 дугаар тушаалаар сувилагч Х.Болорцэцэг 7 хоног бүрийн Мягмар, Пүрэв гаригуудад 08:30-16:30 цагийн хооронд байгууллагын ажилтнуудад анхан шатны үзлэг хийж, зөвлөгөө өгөх, эмчийн жоргүй олгодог дусал, шингэн тарих зэрэг эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор 351 ажилтан эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ авсан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 6.2. | Албан хаагчдын хамрагдалт | 80-аас дээш | 95 хувь | Эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээнд 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар нийт 36 ажилтан хамрагдав.<br>"Монгол фарм ХХК"-тай хамтран ажилтнуудад эрдсийн оношилгоо, шинжилгээ хийх ажлыг зохион байгуулан ажиллаж 42 ажилтан хамрагдсан. |
| 7. | Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал | 7.1. | Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг) | Тухай бүр | 100 хувь | Газрын хөдөлмөрийн "дотоод журам"-ын холбогдох заалтын хүрээнд тайлант хугацаанд<br>20 ажилтан, албан хаагчид:<br>- дэмжлэг 52.200.000 төгрөг,<br>- тусламж 10.900.000 төгрөг, нийт 63.100.000 төгрөгийг тус тус тушаалаар баталгаажуулав. |
| Хэсгийн дундаж – 87.5 хувь | | | | | | |
| **Биелэлтийн хувь – 93.7 хувь** | | | | | | |

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

### 4.1. Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл (Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажилллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтаар баталсан аргачлалыг баримтална)

**ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

| № | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|
| | | **Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал** | |
| 1. | Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Газрын www.invest.ub.gov.mn вэбсайтад БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ цэсэд Эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэл, үндсэн зорилт байгууллагын бүтэц, ТУЗ-ын гишүүд, иргэдийг хүлээн авах цагийн хуваарь, шилэн данс, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам зэргийг байршуулсан.<br>Мэдээллийн самбарт байгууллагын танилцуулга, үйл ажиллагааны ил тод байдал, хүний нөөцийн ил тод байдал, төсөв санхүүгийн ил тод байдал, төлөвлөлт судалгаа, Хууль эрх зүй, Шилэн данс, Төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, Спорт, соёл олон нийтийн арга хэмжээ, Иргэдтэй уулзах цагийн хуваарь, Холбогдох цаг үеийн мэдээлэл болон, Санал хүсэлтийн хайрцаг зэрэг мэдээллүүдийг багтаан байршуулж тухай бүр шинэчилж байна. | 100 хувь |
| 2. | Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг(эх)-ын нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас, болон мэдээллийн самбар, вебсайтад байршуулсан. | 100 хувь |
| 3. | Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | 2018 оны 09 дүгээр сарын 26 ний өдрийн А/50 дугаар тушаалын дагуу газрын www.invest.ub.gov.mn вэбсайтад БАРИМТЫН ЖАГСААЛТ цэсэд<br>Барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээний баримт бичгийн бүрдэл, барилгын угсралтын ажлын гүйцэтгэл олгох баримт бичгийн бүрдэл, зураг төсвийн ажлын гэрээний баримт бичгийн бүрдэл, зураг төсвийн ажлын гүйцэтгэл олгох баримт бичгийн бүрдэл, бусад бичиг баримтууд зэрэг бичиг баримтын бүрдлүүдийг байршуулсан.<br>Мэдээллийн самбарт зураг төслийн ажлын эхний гүйцэтгэл, барилга угсралтын ажлын эхний болон явцын гүйцэтгэл, Барьцаа хөрөнгө чөлөөлөх (Зураг), зураг | 100 хувь |

| | | | |
|---|---|---|---|
| | | тeслийн ажлын эцсийн гүйцэтгэл, барилгын угсралтын ажлын эцсийн гүйцэтгэл, барьцаа хөрөнгө чөлөөлөх (Барилга)<br>Санхүүжилтийн графикт улсын төсвийн хөрөнгө оруулалт, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, явцын график, эцсийн график зэрэг мэдээллүүдийг багтаан байршуулж тухай бүр шинэчилж байна. Манай газрын үйл ажиллагаатай холбоотой иргэд, ААН байгууллагуудын бүрдүүлэлт хийгдэх шаардлагатай албан бичгүүдийн бүрдлүүдыг Төрийн үйлчилгээний Улаанбаатар хотын албан ёсны цахим порталд байршуулсан болно. (eservice.ulaanbaatar.mn) | |
| 4. | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | www.invest.ub.gov.mn вэбсайтад ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ цэсээс газрын үйл ажиллагаатай холбоотой холбогдох хууль, тогтоол захирамж, дүрэм журам, ёс зүйн дүрэм зэргийг байршуулсан.<br>Мэдээллийн самбарын Хууль эрх зүй хэсэгт холбогдох хууль тогтоомж зэргийг бүрэн байршуулсан. | 100 хувь |
| 5. | Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах; | Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын албан вэбсайт болох (www.invest.ub.gov.mn)-аар бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг ил тодоор нийтэлж байна. | 100 хувь |
| 6. | Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх; | 2023 оны 01 дүгээр сарын 02-ний өдрөөс 06 дугаар сарын 23-ны өдрийн хугацаанд нийт 522 баримт бичиг хүлээн авч, гүйцэтгэгч байгууллагийн иргэдэд барьцаа хөрөнгө чөлөөлөх, барилга угсралтын гүйцэтгэлийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Үүнд:<br>1. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 204<br>2. Барилга угсралтын ажлын гэрээ сунгалт 140<br>3. Барьцаа хөрөнгө чөлөөлөх 94<br>4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах 36<br>5. Зохиогчийн хяналтын гэрээ 20<br>6. Зураг төслийн гэрээ сунгалт 18<br>7. Зураг төслийн ажлын гүйцэтгэл 10<br>НИЙТ 522<br>Мөн Нийслэлийн албан хэрэг хөтлөлтийн Edoc системээр дамжуулан цахимаар албан бичиг солилцож байгаатай холбогдуулан гүйцэтгэгч байгууллагуудтай smartoffice.mn сайтаар дамжуулан албан бичгийг солилцон ажиллаж байна. | 100 хувь |
| 7. | Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын | Манай газрын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэх боломжгүй болно. | 100 хувь |

| | | | |
|---|---|---|---|
| | гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх; | | |
| 8. | Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгодоггүй болно. | 100 хувь |
| 9. | Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх; | НХОГ-аас улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хяналт тавин хэрэгжиж буй, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлыг олон нийтэд нээлттэй мэдээллэх ажлыг тогтмол нийтэлж байна. 2023 оны 03 сарын 30-ны өдрийн байдлаар нийт 42 мэдээ мэдээлэл байгууллагын цахим хаягт нийтлэгдэж зохих хэвлэл мэдээллийн байгууллагуудаар түгээгдэж байна. Мөн Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны видео тайлан, контент, 2022 оны цахим тайлан номыг бэлтгэж нийтлэсэн. | 100 хувь |
| | | Хэсгийн дундаж хувь: | 100 хувь |
| | **Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;** | | |
| 1. | Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах; | Тайлант хугацаанд мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас зарласан ажлын байрны сул орон тоог газрын албан ёсны вэб http://invest.ub.gov.mn/ сайт болон мэдээллийн самбарт Төсөл хөтөлбөр, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн 1, Барилгын хяналтын инженер 1, Төлөвлөлт судалгааны мэргэжилтэн 1, Дотоод хяналтын инженер 1 нийт 4 ажлын байр шинээр сонгон шалгаруулах тухай зар байршуулав. Мөн газрын даргын Үндсэн үйл ажиллагааны талаар гарсан А тушаалыг тус сайтад тогтмол байршуулж байна. | 100 хувь |
| 2. | Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/28 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан Ёс зүйн дүрмийг www.invest.ub.gov.mn вэбсайтад байршуулсан.<br>Ёс зүйн зөвлөлийн 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг газрын даргаар 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр батлуулав. Төлөвлөгөөт ажлын хүрээнд сайтад ёс зүйн зөвлөл нэрт бүлэг шинээр үүсгэн холбогдох мэдээ, мэдээллийг тухай бүр ил тод байршуулан ажиллаж байна. | 100 хувь |

| | | | |
|---|---|---|---|
| 3. | Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | www.invest.ub.gov.mn вэбсайтад ИЛ ТОД БАЙДАЛ-Хүний нөөц цэсэд 2023 оны хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, хөтөлбөрийн биелэлт, 2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг байршуулав. | 100 хувь |
| 4. | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх; | Газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/15 дугаар тушаалаар "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ыг *(2021-2024 онд хэрэгжих хугацаатай)* батлав. Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>- 2021 онд жилийн эцсийн биелэлт 90,<br>- 2022 оны жилийн эцсийн биелэлт 94.5,<br>- 2023 оны хагас жилийн биелэлт 98 хувьтай хэрэгжив.<br>Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарч буй мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудын 2022 оны Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг холбогдох дүрэм, журмын хүрээнд зохион байгуулан ХАСХОМ-1, ХАСХОМ-2 тайланг 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 5/644 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв.<br>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 03/950 тоот албан бичгийн дагуу Газрын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 5/638 тоот албан бичгээр хүргүүлэв.<br>Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид нэр дэвшиж буй Дашдоржийн Пүрэвжавын "Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг" хянуулахаар 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 5/1404 тоот албан бичгээр Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэст хүргүүлэн, Авлигатай тэмцэх газрын Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай хариу албан бичгийг www.invest.ub.gov.mn вэбсайтад байршуулав. | 100 хувь |
| 5. | Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх; | Газрын www.invest.ub.gov.mn вэбсайтад албан хаагчдын 2022 оны жилийн эцсийн ажлын үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 218-р тогтоолын дагуу гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт болон мэдлэг ур чадвар, хандлага ёс зүйн үнэлгээг дүгнэн "Хүний нөөц" буланд мэдээлсэн. 2023 оны албан хаагчдын үнэлгээг 2023 оны Хагас жилийн байдлаар үнэлж байна. | 80 хувь |
| | | Хэсгийн дундаж хувь: | 96 хувь |
| | | Хэрэгжилтийн дундаж хувь: | 98 хувь |

## 4.2. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд газрын мэдээллийн самбарт Шилэн данс, соёл, спорт арга хэмжээний төлөвлөгөө, мэдээ мэдээллийн 22 мэдээ шинэчлэн байршуулав.




*Зураг 4.2.-1*

*Хэвлэл мэдээлэл:*

Манай газарт улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хяналт тавин хэрэгжиж буй, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлыг олон нийтэд нээлттэй мэдээллэх ажлын хүрээнд 49 мэдээг газрын цахим хуудас, вэб сайтад нийтлэсэн. Мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах хэлтэс, дүүргүүдийн хэвлэл мэдээллийн албатай холбогдож цахим хуудаст нийтлүүлж байна.

Газрын түүхэн видео контентийг UBS телевизтэй хамтран бэлтгэв.

Үндэсний олон нийтийн радио телевиз, UBS телевизэд Газрын дарга, Ерөнхий инженер нар тус тус 1 удаа ярилцлага, мэдээлэл өгөв.

Барилга.мн сэтгүүлийн 01 дүгээр сарын дугаарт газартай холбоотой мэдээ мэдээллийг бэлтгэн хүргүүлж нийтлүүлэв.

Газрын дотоод үйл ажиллагаа болон дээд газраас ирсэн олон нийтийн арга хэмжээнд оролцсон нийт 14 мэдээ, мэдээллийг бэлтгэн газрын цахим хуудас, вэб сайтад нийтлэв.

*Investpro дотоод мэдээллийн систем:*

Investpro дотоод мэдээллийн системийн баазыг сүүлийн байдлаар хуулж, системийн домэйн хаяг шилжүүлж, системийг хэвийн ажиллагаанд оруулсан. Мөн апплийн appstory -д апликейшн байршуулах Аппль хөгжүүлэгч хөтөлбөрийн эрх нээлгэхэд хэрэгтэй холбогдох материалыг мэйл хаягаар илгээж баталгаажуулсан. Appstore, playstore-т апликейшн байршуулан инженерүүд ашиглахад бэлэн болсон.

Нийслэлийн Засаг даргаас "Нэг систем ашиглах" үүрэг даалгаврийн хүрээнд нийслэлд захиалагчийн хяналт хэрэгжүүлдэг 117 байгууллагуудын холбогдох эрхийг investpro.ub.gov.mn систем дээр холбосон. Мөн investpro.ub.gov.mn систем болон апликейшны шаардлагатай доголдлыг засах, нэмэлт хөгжүүлэлт хийх гэрээ бэлэн болсон.

Манай газрын 22 инженер хоорондын 139 ажлыг шилжүүлж, нэвтрэх эрхийн 41 бүртгэл шинээр нээв.

Investpro дотоод мэдээллийн системд эрх шилжилт, зөвлөмж, хэрэглэгчийн удирдлага, файлын удирдлага, системийн лог, тохируулга, нэгж, барилга угсралт зэрэг цэсүүдэд тухай бүр засварлалт болон хөгжүүлэлт хийж байна.

## 4.3. Төсөв санхүүгийн ил тод байдал

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган 27 мэдээ, мэдээллийг шилэн дансны цахим http://shilendans.gov.mn/ сайтад тухай бүр тайлагнасан. Үүнд:

*Төсөв гүйцэтгэл*: Газрын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ;

*Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт:* Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, гүйцэтгэл, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

*Бусад*:Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн зэргийг мэдээллээ.

## 4.4. Санхүүгийн тайлан мэдээний чиглэлээр

Санхүүгийн үйл ажиллагаагаа Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн хөтлөн явуулдаг. Санхүү, аж ахуйн хэлтэс нь газрын тасралтгүй үйл ажиллагааг хэвийн, үр ашигтай явуулахад бүхий л талаар анхааран ажиллаж байна.

*Хүснэгт 4.4.-1 Санхүүгийн байдлын товчоо урьдчилсан байдлаар (мянган төгрөгөөр)*

| Мөрийн дугаар | Балансын зүйл | Үлдэгдэл | |
|---|---|---|---|
| | | **1 сарын 1** | **6 сарын 30** |
| 1.1.01 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 38,199,699,575.90 | 31,090,526,988.65 |
| 1.1.02 | Дансны авлага | 1,287,279,145.95 | 3,140,457,055.95 |
| 1.1.03 | Татвар, НДШ-ийн авлага | 0.00 | |
| 1.1.04 | Бусад авлага | 2,081,918,401.21 | 2,125,721,047.00 |
| 1.1.06 | Бараа материал | 6,815,900.00 | 7,699,200.00 |
| 1.1.07 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 1,072,277.00 | 6,175,551.00 |
| 1.1.08 | Бусад эргэлтийн хөрөнгө | 405,794,958,694.00 | 405,794,958,694.00 |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 447,371,743,994.06 | 442,166,246,312.60 |
| 1.2.01 | Үндсэн хөрөнгө | 153,972,945.98 | 137,758,178.29 |
| 1.2.02 | Биет бус хөрөнгө | 6,160,000.08 | 3,593,333.43 |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 160,132,946.06 | 141,351,511.72 |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **447,531,876,940.12** | **442,307,597,824.32** |
| 2.1.1.01 | Дансны өглөг | 2,054,005,489.00 | 1,982,836,939.00 |
| 2.1.1.02 | Цалингийн өглөг | 0.00 | |
| 2.1.1.03 | Татварын өр | 29,663,927.21 | |
| 2.1.1.08 | Урьдчилж орсон орлого | 2,168,701,171.81 | 2,180,956,919.41 |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 4,252,370,588.02 | 4,161,918,483.68 |
| 2.1.2.02 | Нөөц (өр төлбөр) | 34,527,581,592.79 | 29,005,697,079.84 |
| 2.1.2.06 | Урт хугацаат өр төлбөрийн дүн | 34,527,581,592.79 | 29,005,697,079.84 |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 38,779,952,180.81 | 33,167,615,563.52 |
| 2.3.01 | Өмч: - төрийн | 78,198,418.73 | 78,198,418.73 |
| 2.3.09 | Хуримтлагдсан ашиг | 408,673,726,340.58 | 409,061,783,842.07 |
| 2.3.09.1 | Тайлангийн үеийн ашиг | 0.00 | 388,057,501.49 |
| 2.3.09.2 | Өмнөх үеийн ашиг | 408,673,726,340.58 | 408,673,726,340.58 |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 408,751,924,759.31 | 409,139,982,260.80 |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **447,531,876,940.12** | **442,307,597,824.32** |

*Хүснэгт 4.4.-2 2023 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтод түвшингийн хагас жилийн урьдчилсан байдлаарх биелэлт (мянган төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | | 2023 он | |
|---|---|---|---|---|
| | | | Зорилт | Гүйцэтгэл 2023.06.25 |
| 1 | Орлого | Борлуулалтын орлого (Нийслэлээс, ОНХС) | 869,068 | |
| | | Борлуулалтын орлого (Улс) | 2,434,164 | 2,482,805 |
| | | Борлуулалтын орлого (Төслийн нэгжүүд) | 2,547,447 | |
| | | Үйл ажиллагааны бус орлого (Хүүгийн орлого) | 30,000 | 9,195 |
| | | **Нийт орлого** | **5,880,679** | **2,492,000** |
| 2 | Зардал | ББӨртөг | 188002.7 | 148049 |
| | | Цалин | 2586470.3 | 1302281 |
| | | Хоол унаа | 343728 | |
| | | НД, ЭМДШ 11 хувь | 358913.3219 | 157139 |
| | | Засвар үйлчилгээ | 19105.6 | 4595 |
| | | Сэлбэг засвар | 21262.8 | 8623 |
| | | Түрээс ашиглалт | 518856 | 241647 |
| | | Томилолт | 0 | |
| | | Элэгдэл | 95000 | 23175 |
| | | Тээвэр, даатгал | 21154.304 | 820.2 |
| | | Шуудан холбоо | 24204 | 6906.17 |
| | | Шатахуун | 48416.6 | 14896.72 |
| | | Сургалт | 42000 | 2410 |
| | | Хангамжийн материал | 29177.5 | 19650 |
| | | Хөдөлмөр хамгаалал | 31000 | 6822 |
| | | Бичиг хэрэг | 69572.9 | 22188 |
| | | Бусад | 83600 | 19799 |
| | | Үйл ажиллагааны бус | 348080 | 124936 |
| | | **Нийт зардал** | **4828544.026** | **2103937.09** |
| 3 | Татварын өмнөх ашиг (алдагдал) | | 1052134.974 | 388062.87 |
| 4 | Татварын зардал | | 105213.4974 | |
| 5 | **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | | **946921.4767** | **388062.87** |
| 6 | **Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал** | | **0.82** | **0.84** |

Нийт хөрөнгийн 99 хувийг эргэлтийн хөрөнгө, 7 хувийг өр төлбөр эзэлж байна. Эргэлтийн хөрөнгийн 91 хувийг бусад эргэлтийн хөрөнгө буюу дуусаагүй хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд олгосон санхүүжилт эзэлж байна. Мөн хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн харилцах дансанд 29,0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2023 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтод түвшингийн хагас жилийн урьдчилсан байдлаарх биелэлт (мянган төгрөгөөр)







*График 4.4.-1*

2,492,000.00 мянган төгрөгийн орлогын 2,482,00.00 төгрөг нь техник хяналтын орлого. 2,103.9 сая төгрөгийн зардлын 69 хувь буюу 1,459.2 сая төгрөгийг Цалин, НДШ-ийн зардал, Түрээсийн зардал нь 241,6 сая буюу нийт зардлын 12 хувь, Үйл ажиллагааны зардал нь 403,1 сая төгрөг буюу нийт зардлын 19 хувийг тус тус эзэлж байна. (Техникийн нөхцөл болон зохиогчийн хяналтын зардал, Засвар үйлчилгээ, шуудан холбоо, бичиг хэрэг, хангамжийн материал, сургалт, шатахуун)

## ТАВДУГААР БҮЛЭГ.БУСАД МЭДЭЭЛЭЛ

### 5.1. Дотоод ажлын чиглэлээр (зохион байгуулсан ажил, хурал, техникийн зөвлөлийн хурал)

Тайлант хугацаанд техникийн зөвлөлийн хурал 10 удаа зарлагдан хуралдаж нийт 126 ажлыг хэлэлцэн холбогдох шийдвэр гаргав. Үүнд:

- Гэрээний хугацаа сунгах 90
- Магадлашгүй ажлын зардал шийдвэрлүүлэх 17
- Шийдэл гаргах тухай 10
- Гэрээ цуцлах тухай 9

*Зураг төсөл, барилга угсралтын ажлын техникийн нөхцөл, сунгалт:*

*Техникийн нөхцөл:* 2023 оны хагас жилийн байдлаар барилга байгууламжийн зураг төсвийн болон түлхүүр гардуулах нөхцөлтэй ажлын нийт 59 техникийн нөхцөл хүсч, 28 техникийн нөхцөл олгогдсоныг гүйцэтгэгчид хүргүүлэв. Үүнд:

Хүргүүлсэн техникийн нөхцөл хүсэлт:

- УБЦТС ТӨХК –13
- УБДС ТӨХК -16
- УСУГ ОНӨААТҮГ- 14
- МХС ХХК - 16

Олгогдсон техникийн нөхцөл:

- УБЦТС ТӨХК –7
- УБДС ТӨХК -8
- УСУГ ОНӨААТҮГ- 8
- МХС ХХК – 5

*Зохион байгуулсан ажлын хүрээнд:*

*5.1.1 Газрын хэмжээнд зохион байгуулагдсан тэмцээн:*

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/13 дугаар тушаалаар "Соёл, спорт хамтлаг"-ийн ажлын хэсэг байгуулагдав. 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Ажлын хэсэг хуралдаж, хийх ажлын төлөвлөгөө боловсруулж, газрын даргаар батлуулан ажиллаж байна.

Албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны эв нэгдлийг сайжруулах, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор газрын "Сагсан бөмбөг"-ийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах удирдамж, хөтөлбөр боловсруулан 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр газрын даргаар батлуулав. 2023 оны 03 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулан явуулж, нийт 76 албан хаагч оролцов.



*Зураг №5.1-1*

Эрэгтэй, эмэгтэй төрөлд 7 багийн тамирчид амжилттай оролцсоноос:

Эрэгтэй баг 1-р байр Black Panthers баг

2-р байр Bears баг

3-р байр UB Gangsta баг



*Зураг №5.1-2*

Эмэгтэй баг 1-р байр Apex баг

2-р байр Аравт баг

3-р байр Black Panthers баг багууд тус тус шалгарч, шилжин явах цом, мөнгөн шагналаар шагнагдсан.



*Зураг №5.1-3*

2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр газрын даргаар батлуулсан удирдамж, хөтөлбөрийн дагуу "Гар бөмбөг-ийн" аварга шалгаруулах тэмцээнийг 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Ерөнхий боловсролын 48 дугаар сургуулийн спорт зааланд зохион байгуулж, 7 багийн нийт 69 тамирчид оролцов. Үүнд:

Эрэгтэй баг 1-р байр Hunters баг

2-р байр UB Gangsta баг

3-р байр Black Panters баг



*Зураг №5.1-4*

Эмэгтэй баг 1-р байр Black Panters баг

2-р байр UB Gangsta баг

3-р байр Apex баг багууд тус тус шалгарч, шилжин явах цом, медаль, мөнгөн шагналаар шагнагдсан.



Зураг №5.1-5

*5.1.2 Бусад байгууллагаас зохион байгуулагдсан тэмцээн, арга хэмжээ:*

1.Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр ирүүлсэн 3/38 тоот албан бичгийн хүрээнд газрын албан хаагчдыг “Цасны баяр” өвлийн биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцуулахаар төлөвлөгөө гарган, хөтөлбөр боловсруулан 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдөр газрын даргаар батлуулсан. 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн газрын даргын А/12 дугаар тушаалын хүрээнд “Цасны баяр”-ын арга хэмжээг зохион байгуулав. 2023 оны 02 дугаар сарын 11-ний өдөр Хандгайтын “Янзага” зуслангийн цанын баазад зохион байгуулагдсан арга хэмжээнд нийт 65 албан хаагч хамрагдав. Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас зохион байгуулсан бүжгийн тэмцээнд Э.Одчимэг, А.Тамир нар амжилттай оролцож 5 дугаар байр эзлэв.

Газрын албан хаагчдын дунд 3 төрлийн тэмцээн (цасны сумо, цасны бүжиг, морин барилдаан) зохион байгуулж, түрүүлсэн албан хаагчдыг мөнгөн шагналаар шагнав. Хэлтэс бүр эко хоол бэлтгэн цэвэр, эрүүл агаарт хооллов. Хоолны зураг, тэмцээн зохион байгуулсан дүрс бичлэгийн Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Ахлах мэргэжилтэнд viber-аар илгээсэн. Нийслэлийн хэмжээнд нийлбэр дүнгээр 4 дүгээр байр эзлэв.



Зураг №5.1-6

2.Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 01/666 тоот албан бичгийн хүрээнд Ерөнхий менежерийн нэрэмжит спортын 5 төрөлт (сагсан бөмбөг, гар бөмбөг, дартс, ширээний теннис, шатар) тэмцээнд газрын албан хаагчдыг оролцуулахаар бэлтгэл ажлыг хангав.

Тэмцээн 2023 оны 05 дугаар сарын 02-07-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, давхардсан тоогоор нийт 37 албан хаагч төрөл тус бүрд амжилттай оролцов.



*Зураг №5.1-7*

3.Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр ирүүлсэн 2/118 тоот албан бичгийн хүрээнд албан хаагчдыг “Эрүүл мэндийн цахим гүйлт 2023”-д оролцуулахаар газрын дотоод сүлжээгээр мэдээлэл хүргэн ажиллав. “Эрүүл мэндийн цахим гүйлт 2023” арга хэмжээ 2023 оны 05 дугаар сарын 01-07-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, 6 хэлтсийн 9 албан хаагч, нийт 139.4 км зам гүйж амжилттай оролцов. Үүнд:

- Хууль, дотоод хяналтын хэлтэс 1 албан хаагч 3.47 км
- Төлөвлөлт судалгааны хэлтэс 1 албан хаагч 3.81
- Мэдээллийн технологийн хэлтэс 1 албан хаагч 7.3 км
- Барилга захиалагчийн хэлтсийн 3 албан хаагч 18.19 км
- Захиргааны хэлтэс 1 албан хаагч 32 км
- Санхүү, аж ахуйн хэлтэс 2 албан хаагч 74.63 км




*Зураг №5.1-8*

4.Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/327 дугаар захирамжийн хүрээнд Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 3/138 тоот хамтран ажиллах тухай ирүүлсэн албан бичиг, удирдамжийн “Улаанбаатар марафон-2023” зохион байгуулалтын ажлыг хангаж, албан хаагчид амжилттай оролцов. “Улаанбаатар марафон-2023” гүйлтийн талаарх мэдээллийг байгууллагын дотоод сүлжээнд байршуулан, ажилтнуудад мэдээлэл хүргэсэн. 5 км-ийн зайд гүйх 9, 10 км-ийн зайд гүйх 1 албан хаагчийн мэдээллийг http://ubmarathon.hipay.mn/ хаягаар онлайнаар бүртгэлжүүлэн, төлбөрийг hipay апплейкешнаар хийж баталгаажуулав. Энгэрийн дугаарыг Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас авч, албан хаагчдад олгов. Улаанбаатар марафон-2023” Олон улсын гүйлт 2023 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулагдаж, нийт 10 албан хаагч амжилттай оролцов.



*Зураг №5.1-9*

2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар нийт 6 тэмцээн, уралдаан зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 266 албан хаагч хамрагдав.

5.Газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн "Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах тухай" А/28 дугаар тушаал, Гамшгийн эрсдлийг бууруулах төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/194 тоот захирамж "Стратегийн команд штабын сургууль зохион байгуулах" бэлэн байдлын үзлэгийг хуваарийн дагуу зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд Бодь цамхаг, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран "Гамшгаас хамгаалах тактик сургуулилт"-ыг BOGD TOWER барилгад хийж нийт ажилтнуудыг болзошгүй гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн үед өөрийгөө болон бусдыг хамгаалах, газар хөдлөлтийн үед түгшүүрийн дохиогоор барилга байгууламжаас гарах, зам гарцын аюулгүй байдал болон эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, гал унтраах тактикийн дадлага хийсэн ба газрын 18 ажилтан идэвхтэй оролцон хамтран ажиллалаа.




*Зураг №5.1-10*

Нийслэлийн Онцгой байдлын газартай хамтран "Газар хөтлөлтийн гамшгийн эрсдлийг бууруулах, аюулгүй байдлыг хангах, тохиолдсон үед авах арга хэмжээ" сэдэвт сургалтыг 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 09 цагт 503 тоот өрөөнд зохион байгууллаа. Сургалтанд 62 албан хаагч хамрагдав.




*Зураг №5.1-11*

Онцгой байдлын газраас орон даяар зохион байгуулсан "Стратегийн команд штабын сургууль зохион байгуулах" бэлэн байдлын сургуулилтанд газрын албан хаагчид 100 хувийн ирцтэй оролцов.



Зураг №5.1-12

Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн төлөвлөгөөнд тусгасны дагуу галын самбар, хор, бусад хэрэгслийг худалдан авч байршуулан, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Гамшгийн сургуулилт бусад зар мэдээллийг нийт 6 удаагийн давтамжтайгаар газрын дотоод мэдээллийн хэрэгслүүдэд байршуулан ажиллав.




Зураг №5.1-13

Нийслэлийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан “Бэлэн бай” аянд манай хамт олон нэгдэн, Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Турк Улсад болсон газар хөдлөлтийн тухай” гэрэл зургийн “Нуранги” үзэсгэлэнг 2023 оны 05 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд нийт ажилтнууд үзэж сонирхов.



Зураг №5.1-14

*5.1.2 Хөтөлбөр, аяны хүрээнд:*

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III” хүрээнд хийх ажлын төлөвлөгөө боловсруулан Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын Захиргааны хэлтсийн даргаар 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр батлуулан дараах ажлыг хийж гүйцэтгээд байна.Үүнд:

-2022 оны 04 сарын 21-ний өдрөөс эхлэн байгууллагын цахим хаяг (http://invest.ub.gov.mn/, НХОГ-Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын Газар фэйс бүүкийн хуудас)-аар мэдээ, мэдээлэл нийтлэхдээ байгууллагын оноосон нэр (Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар)-ийг кирилл болон үндэсний бичгээр зэрэгцүүлэн бичиж хэвшээд байна. 2023 оны 05 дугаар сараас байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг нийтлэхдээ туршилтаар кирилл болон үндэсний бичгээр зэрэгцүүлэн бичиж, оруулж байна.




*Зураг №5.1-15*

“Монгол бичигтэн-НХОГ” дотоод сүлжээгээр мэдээ, мэдээлэл болон албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг нэмэгдүүлэхээр монгол бичгийн видео хичээлийг (МУ-ын гавьяат багш Ш.Чоймаа) 7 хоногт 1 удаа оруулан ажиллаж байна. 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар нийт 3 удаагийн хичээлийг оруулав.




*Зураг №5.1-16*

Монгол хэл бичгийн багш судлаачдын үндэсний холбоотой хамтран албан хаагчдаас монгол бичгийн түвшин тогтоох, сургалтад хамруулах хэрэгцээ шаардлага байгаа эсэх судалгааг 2023 оны 05 дугаар сарын 23-25-ны өдрийн дуустал байгууллагын дотоод сүлжээгээр google.doc form ашиглан цахимаар хэлбэрээр авч, хэлтсийн даргад танилцуулав. Судалгаанд хамрагдвал зохих 87 албан хаагчаас 74 буюу 85.05 хувь нь хамрагдаж, 13 албан хаагч хамрагдаагүй.

Судалгаанаас дүгнэхэд 69 хувь буюу 51 албан хаагч уншиж чадна, дүрэм мэдэхгүй, 85 хувь буюу 63 албан хаагч монгол бичгийн Mongolian Baiti фондоор бичиж чадахгүй, 62 хувь нь буюу 46 албан хаагч анхан шатны сургалтад хамрагдах хүсэлтэй байгаа нь цаашид албан хаагчдыг монгол бичгийн сургалтад хамруулах хэрэгцээ шаардлага байна.

“Нийслэлийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд:

- Жендэрийн Үндэсний хороотой хамтран 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр “Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх нь” танхимын сургалт зохион байгуулж, нийт 53 албан хаагч хамрагдав.

- Газрын дотоод сүлжээгээр нийт албан хаагчдад зориулан жендэрийн талаарх мэдээ, мэдээллийг 3 удаа хүргэв.

- “Жендэрийн үндэсний хорооноос “Харилцан хүндэтгэе” надаас, таниас, эхлэлтэй уриан дор нэг сарын аянд манай газар нэгдсэн. Аяны хүрээнд төлөвлөгөө боловсруулж 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр батлуулсан. Аяны хүрээнд байгууллагын дотоод сүлжээ, цахимаар олон нийтэд түгээх, байгууллагын ажилтан, албан хаагчид дунд жендерийн тэгш эрхийн мэдрэмжийн тухай тодорхойлох сорил явуулж, нэгтгэл тайланг 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 5/1025 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хүргүүлэв.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01/66 тоот албан бичгийн дагуу Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн халтиргаа гулгааг арилгах, хог хаягдлыг цэвэрлэх зорилгоор гадна орчны 50 метр хүртэлх зам талбай, бүх нийтийн их цэвэрлэгээ “Ердөө 90 минут цэвэрлэгээг 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр, Хоггүй шинэлье их цэвэрлэгээг 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 11:00-12:30 цагт зохион байгуулагдсан. Манай газраас I дүгээр ээлжээр 40 албан хаагчид идэвхтэй оролцсон ба II дугаар ээлжинд 23 ажилтан оролцож Монголын хөрөнгийн биржийн баруун урд талын явган хүний мөстсөн талбай, Бодь цамхагийн үүдний явган хүний зам, болон талбайг цэвэрлэв.

“Хотоо цэвэрлье” бүх нийтийн хаврын их цэвэрлэгээг 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр 11:00 цагт зохион байгуулж хөтөлбөр боловсруулан байгууллагын дотоод сүлжээгээр зарыг байршуулан, Хэлтсийн даргад танилцуулсан. Манай газраас нийт 75 албан хаагчид оролцсон. Аяны хүрээнд хийсэн ажлын илтгэх хуудас бичиж Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хөрс, орчны бохирдол ариутгал хариуцсан мэргэжилтэнд dispatcher.ub@yahoo.com цахим хаягаар хүргүүлэв.



*Зураг №5.1-17*

Эх дэлхийн өдрийг тохиолдуулан Экологийн цагдаагийн албанаас “Хүн бүр байгаль хамгаалагч” нөлөөллийн аянг 2023 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 10:00 цагт Монголын хүүхдийн ордны талбайд зохион байгуулагдаж, манай газраас нийт 30 албан хаагчид оролцов.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл хүн” үндэсний хөдөлгөөн “Цаг гаргая” биеийн тамирын арга хэмжээг орон даяар 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 06 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж байгаа бөгөөд “Эрүүл мэндийн цахим гүйлт 2023” аяны удирдамжийн дагуу цахим гүйлтэд оролцох албан хаагчдад сурталчилан мэдээллэж STRAVA гүйлтийн аппликейшн суулгах зааварчилгаа авч 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 07-ны өдөр цахим гүйлтэд идэвхтэй оролцож нийт 32 км гүйсэн зураг, мэдээллийг холбогдох газарт хүлээлэв.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн Хаврын мод тарих арга хэмжээнд оролцсон тайлан мэдээг Нийслэлийн Байгаль орчны газарт 2023 оны 05 дугаар сарын 22-ны 5/1813 тоот албан бичгээр хүргүүлэв.



*Зураг №5.1-18*

## 5.2. Сургалтын чиглэлээр

Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар газрын "Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд албан хаагчдыг сургалтад хамруулсан болон сургалт зохион байгуулсан ажлын илтгэх хуудас, ирцийн бүртгэлийг (тухайн албан хаагчаар гарын үсэг зурж баталгаажуулах) тухай бүр хийж, хэлтсийн даргад танилцуулан, баталгаажуулан ажиллав.

Хагас жилийн байдлаар хувь хүнийг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр 50 сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 404 албан хаагч хамрагдав. Үүнд:

- Гадаад томилолт, семинар, үзэсгэлэн 4 удаа,8 албан хаагч
- Дотоод сургалт 4 удаа,164 албан хаагч
- Зөвлөгөөн, хэлэлцүүлэг 6 удаа, 31 албан хаагч
- Хувь хүний хөгжлийн сургалт 4 удаа, 8 албан хаагч
- Мэргэшүүлэх сургалт 32 удаа, 193 албан хаагч тус тус хамрагдав.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд газрын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай шууд холбоотойгоос бусад сургалтад төсөв гаргах боломжгүй тул Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулагдаж байгаа төлөвлөгөөт сургалтад газрын албан хаагчдыг хамруулан ажиллаж байна.

Тус төвийн сар бүрийн сургалтын төлөвлөгөө авч, хэлтсийн дарга нарт танилцуулан, санал авч нэгтгэн, сургалтад хамрагдах ажилтнуудын мэдээллийг Ulaanbaatar ERP системийн Сургалт хөгжил цэсэд тухай бүр бүртгэл үүсгэн ажиллав.

## 5.3. Гэрээ эрх зүйн чиглэлээр

2023 оны хагас жилийн байдлаар барилга угсралтын ажлын гэрээ, зөвлөх үйлчилгээний гэрээ, барилга угсралтын ажлын болон зөвлөх үйлчилгээний гэрээний сунгалт, зохиогчийн хяналтын гэрээ, захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэх гэрээ, захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэх гэрээний сунгалт, гэрээ цуцалсан зэрэг нийт 374 (давхардсан тоогоор) гэрээг хянан баталгаажуулсан.

Хянан баталгаажуулсан гэрээг ангилбал:

- Барилга угсралтын ажлын гэрээ сунгалт 149
- Барилга угсралтын ажлын гэрээ106
- Зохиогчийн хяналт хийх гэрээ 66
- Захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэх гэрээ 25
- Зөвлөх үйлчилгээний ажлын гэрээ сунгалт 21
- Зөвлөх үйлчилгээний ажлын гэрээ 6
- Гэрээ цуцалж дүгнэсэн 1




*График 5.3.-1*

Мөн хагас жилийн байдлаар барилга угсралтын ажлын гүйцэтгэл, зохиогчийн хяналтын гүйцэтгэл, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэл зэрэг нийт 265 гүйцэтгэл хянан баталгаажуулсан. Хянан баталгаажуулсан гүйцэтгэлийг ангилбал:

- Барилга угсралтын ажлын гүйцэтгэл- 215
- Зохиогчийн хяналтын гүйцэтгэл- 46
- Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэл-4




*График 5.3.-2*

Барьцаа хөрөнгө чөлөөлүүлэх 95 хүсэлтийг хянан баталгаажуулсан байна. Хөдөлмөрийн дотоод журам болон бусад дүрэм журмын төсөлд санал өгөх, нийт үнэлгээний хороо байгуулах 15 тушаалын төсөлд болон бусад тушаал, шийдвэрийн төслүүдийг хянан ажилласан байна.

2022 оны мөн үед нийт 248 гэрээний мэдээллийн сан үүсгэсэн. Үүнд:

- Барилга угсралтын ажлын гэрээний сунгалт - 154
- Барьцаа хөрөнгө чөлөөлүүдэх хүсэлт 134
- Зохиогчийн хяналтын гэрээ нийт - 61
- Захиалагчийн техник хяналт хийх гэрээ нийт - 17
- Зөвлөх үйлчилгээний ажлын гэрээ нийт – 11
- Зөвлөх үйлчилгээний гэрээний сунгалт - 3
- Захиалагчийн техник хяналтын гэрээний сунгалт - 2

Тайлант хугацаанд дүүргийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй төсөл арга хэмжээний 321 удаагийн (давхардсан тоогоор) явцын болон эцсийн гүйцэтгэлийн бичиг баримтыг хянасан байна. Үүнийг ажлын төрлөөр авч үзвэл:

*Хүснэгт 5.3.-1 Хянасан гүйцэтгэлийг төрлөөр*

| Д/д | Ажлын төрөл | Ажлын тоо (2023 оны хагас жил) |
|---|---|---|
| 1 | Барилга угсралт | 53 |
| 2 | Инженерийн шугам сүлжээ/дэд бүтэц | 24 |
| 3 | Зураг төсөв | 7 |
| 4 | Тохижилт | 43 |
| 5 | Их засвар | 46 |
| 6 | Гэрэлтүүлэг | 4 |
| 7 | Тоног төхөөрөмж/камержуулалт | 4 |
| 8 | 90/10-ийн 5%-ийн санхүүжилт | 34 |
| **НИЙТ** | | **215** |

*Хууль, эрх зүйн чиглэлээр:* Иргэний болон Захиргааны хэргийн шүүхийн шатанд нийт 13 хэрэг маргаан байна. Үүнээс Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 4 хэрэг, Захиргааны хэргийн хяналтын шатны шүүхийн шатны шүүхэд 1, Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 5, эцэслэн шийдвэрлэгдсэн буюу шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон 3 хэрэг байна. Эцэслэн шийдвэрлэгдэж шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон Захиргааны 1 хэрэг, Иргэний 2 хэрэг байна. Үүнд:

1.Нэхэмжлэгч Гангар инвест ХХК-ийн нэхэмжлэлтэй Баянзүрх дүүргийн 8,16 дугаар хорооны нутаг дэвсгэрт хийгдэх гэр хорооллын дахин төлөвлөлтийн орон сууцны дэд бүтцийн газар чөлөөлөхөд зарцуулсан 3.670.640.200 (гурван тэрбум зургаан зуун далан сая зургаан зуун дөчин мянга хоёр зуу)төгрөгийн зардлын санхүүжилтийг шийдвэрлэх үүргээ биелүүлээгүй Нийслэлийн Засаг даргын эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоож уг 3.670.640.200 (гурван тэрбум зургаан зуун далан сая зургаан зуун дөчин мянга хоёр зуу)төгрөгийн зардлын санхүүжилтийг зохих журмын дагуу шийдвэрлэж Гангар инвест ХХК, Вешн девелопмент ХХК-д төлөхийг Нийслэлийн Засаг даргад даалгах, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 147 дугаар тогтоолын Гангар инвест ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон байна.

2.Нэхэмжлэгч Г.Дэлгэрсайханы нэхэмжлэлтэй ажлаас үндэслэлгүйгээр халсан болохыг тогтоолгох, урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд эгүүлэн томилуулах, ажилгүй байсан хугацааны нөхөн олговор гаргуулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийг нөхөн баталгаажуулахыг даалгах, 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн “Сахилгын шийтгэл ногдуулах тухай” тушаалыг хүчингүй болгуулах иргэний хэрэг эцэслэн шийдвэрлэгдэж нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн байна.

3.Хариуцагч Чингис хаан банкинд холбогдох 580.000.000 төгрөг гаргуулах нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Бусад захиргааны болон иргэний хэрэг маргааны хувьд тухай бүр холбогдох тайлбарыг өгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байна. Шүүхийн шатанд байгаа хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдуулан нийт 34 удаа шүүх хуралд оролцсон байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс хийгдсэн шүүхийн 2 үзлэгт (А.Ганбатын нэхэмжлэлтэй Сүхбаатар дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт үер усны далд байгууламж, бетон цутгалтын ажил хийлгэхдээ тендер зарлаж, тендер гүйцэтгэгчээр хууль бус үйл ажиллагаа явуулуулсны улмаас учирсан хохиролд 61.200.000 төгрөгийг хариуцагчаас гаргуулан надад олгох шийдвэрийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.7 заасны дагуу гаргуулах захиргааны хэрэг, Хариуцагч Чингис хаан банкинд холбогдох 580.000.000 төгрөг гаргуулах иргэнхий хэрэг ) тус тус оролцсон байна.

Баянзүрх дүүргийн Цагдаагийн хоёрдугаар хэлтэст иргэн М.Хатанбаатар, Н.Даваацэрэн нарт холбогдуулан гомдол гаргасан ба одоогоор мөрдөн байцаалтын шатанд байна. (Цэцэрлэгийн барилга худалдан авах, 150 ор, Баянзүрх дүүргийн 6 дугаар хороо гүйцэтгэгч Тэтү ХХК)

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад нийт 7 шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт ажиллагаа хуулийн дагуу хийгдэж байна.

### 5.4. Архивын чиглэлээр

Архивт баримт хүлээн авах хуваарийг газрын даргаар 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр батлуулав. Албан хаагчдад Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/222

дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын хэрэгжилтийг ханган зааварчилгаа өгч ажиллав. Байгууллагын архивт байнга хадгалах 424 хн, түр хадгалах 691, 70 жил хадгалах 10, тусгай төрөл 86 нийт 1271 хадгаламжийн нэгж хүлээн авав. Данс, бүртгэлийг бэлтгэн Баримт нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэн ажиллаж байна. Ажлын явц 90 хувьтай байна. 2023 онд хүлээн авсан баримтыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал 17 хувиар өссөн байна.




*График 5.4.-1*

Газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр баталсан “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”,

Захиргааны хэлтсийн даргын 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр баталсан “Тендер, гүйцэтгэлийн баримтаар цахим архив үүсгэх заавар”-ыг тус тус хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Архивт хадгалагдаж буй байнга, түр, 70 жил хадгалах 361 хадгаламжийн нэгжийг аудит болон мэргэжилтнүүдийн гаргасан хүсэлтийг дагуу түр олгосон баримтын бүртгэл хөтлөн хүлээлгэн өгч ажиллав.




*График 5.4.-2*

Төрийн архивт цахим нөхөн бүрдүүлэлт хийх ажлын хүрээнд 2022 оны газрын даргын боловсон хүчний чиглэлээр гаргасан 159, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гаргасан 93 тушаалуудыг “UB ERP” Archive eDoc программд агуулга тодорхойлон шивж, нягтлан шалгалтыг хийж дуусгав. Нийт 252 тушаалуудыг UB.Erp.mn Archive дэд системд цахим архив үүсгэн, Нийслэлийн Архивын газарт хүлээлгэн өгөв.

2022 оны тушаалуудыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал 16.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




*График 5.4.-3*

## 5.5. Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах чиглэлээр

*Тайлант хугацаанд их засвар, тохижилтын 37, Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ 23, нийт 61 төсөл, арга хэмжээнд комисс ажиллан байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.*

*5.5.1.Барилга байгууламжийн ажил:* 5.1 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 3 төсөл, арга хэмжээнд байнгын ашиглалтад оруулах комисс ажиллан хүлээлгэж өгсөн. Үүнд:

1.Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй цэцэрлэгийн барилга, 150 ор, (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 11 дүгээр хороо) гүйцэтгэгч Дэрэннаран ХХК







*Зураг 5.5.-1*

2.Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Толгойт хөгжлийн төв, Спорт заал, (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг) гүйцэтгэгч Энэрэлт Их Эрдэнэ ХХК






*Зураг 5.5.-2*

3. Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн цогцолбор барилга барих (Нисэхийн бүс), гүйцэтгэгч Жигүүр-Эрдэнэ ХХК








*Зураг 5.5.-3*

*5.5.2.Инженерийн шугам сүлжээний ажил:* 123.0 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй инженерийн шугам сүлжээний 16 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. Үүнийг задалж үзвэл:

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлын хүрээнд хэрэгжсэн 3 төсөл, арга хэмжээ:

1. Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Сүхбаатар дүүргийн 9, 10, 11 дүгээр хороо, Орон сууцны VII хороолол орчмын Б хэсэгчилсэн талбайн УДДТ-ийн барилга, тоног төхөөрөмж, гадна дулааны шугамын ажил, гүйцэтгэгч "Түшээ Өргөө Трейд" ХХК, "Гэрэлт Оньс" ХХК-иудын түншлэл,





*Зураг 5.5.-4*

2.14 дүгээр хорооллын цахилгааны 110/35/10кв-ын дэд станцын гаргалгаа 4 ком, 10кв-ын хаалттай хуваарилах байгууламж 3 ком, 10кв-ын хаалттай дэд өртөө 12 ком, 10кв-ын 18.4 км кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил, гүйцэтгэгч Моннис урбан девелопмент ХХК, Бүрд констракшн ХХК, Эрчим концерн ХХК, Биндэгноров ХХК, Шугам ХХК-иудын түншлэл

3.Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэр орчмын "В" хэсэгчилсэн талбайн гадна инженерийн шугам сүлжээний ажил, гүйцэтгэгч Батхэрэйд ХХК,

*5.5.3.Цэцэрлэгийн барилгын дулаан хангамжийн 1 ажил:*

1. 320 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга, 960 болон 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын гадна инженерийн шугам сүлжээний ажил (Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо), гүйцэтгэгч ГЦЦ ХХК,

*5.5.4.Хуучин барилгыг буулгаж, дахин барилгажуулах ажлын хүрээнд хийгдэж буй гадна дулаан хангамжийн 2 төсөл, арга хэмжээ:*

1. Давхарын 9, 10 дугаар байрыг буулган дахин барилгажуулах төслийн Дулаан хангамжийн ажил (БГД, 4 дүгээр хороо), гүйцэтгэгч Тэргүүн чансаа ХХК,
2. Баянгол дүүргийн 2 дугаар хороо 26, 27 дугаар байруудыг буулгаж, дахин барилгажуулах төсвийн хүрээнд шинээр барих 16 давхар барилгын гадна дулаан хангамжийн ажил, гүйцэтгэгч И Пи Эс Групп ХХК

*5.5.5.Үерийн далан сувгийн барилга байгууламжийн 1 төсөл арга хэмжээ:*

1. Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Үерийн хамгаалалтын далан, 1.3 км (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 10, 28 дугаар хороо), гүйцэтгэгч Мэлч-Анд ХХК,

*5.5.6.Цахилгаан хангамжийн ажил:*

103,8 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй барилга байгууламжийн 9 төсөл, арга хэмжээний гадна цахилгаан хангамжийн ажилд комисс ажиллуулж, ашиглалтад оруулсан. Ингэснээр үндсэн барилгыг байнгын ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг хангуулан ажилласан байна.

*5.5.7.Гэрэлтүүлэгийн ажил*:

0.3 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй гэрэлтүүлгийн 3 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн байна. Үүнд:

1. Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо, Гэрэлтүүлгийн ажил, гүйцэтгэгч Баянзүрх прогресс ХХК,
2. Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Баянзүрх дүүргийн 29 дүгээр хороо, Гэрэлтүүлгийн ажил, гүйцэтгэгч Өндрийн-Удам ХХК,
3. Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадны засвар, гэрэлтүүлэг камержуулалт (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1, 3, 7, 19, 23 дугаар хороо) Багц-2 Гэрэлтүүлгийн ажил, гүйцэтгэгч Хустайн шил ХХК,

*5.5.8.Тохижилтын ажил:*

Нийт 1.8 тэрбум төгрөгийг гэрээний дүнтэй 17 төсөл арга хэмжээнд байнгын ашиглалтад оруулах комисс ажиллан хүлээлгэж өгөөд байна. Нийслэлийн засаг даргын 2022 оны 2 дугаар сарын 18-ны А/225 дугаар захирамжийн хүрээнд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр санхүүжих 16.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий тохижилтын ажил манай газарт 2022-2023 онд дамжин хэрэгжиж байна. Энэхүү нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хийгдэж буй багц ажлын хүрээнд 1000 $м^2$ талбайг тохижуулах юм. Гүйцэтгэгч Хот тохижилтын газар.

Үүнд: 2023 оны хагас жилийн байдлаар Баянгол дүүргийн 1, 3, Баянзүрх дүүргийн 11, Сүхбаатар дүүргийн 4, 7, Хан-Уул дүүргийн 10, Чингэлтэй дүүргийн 6, 16 дугаар хорооны заагдсан байршлуудад 3х3 сагсан бөмбөгийн талбай байгуулах, сандал хогийн сав

байрлуулж, гэрэлтүүлэг суурилуулах ажлууд тус тус хийгдэж ашиглалтад орсон. Гүйцэтгэгч Хот тохижилтын газар,

1. Баянзүрх дүүргийн 5, 7 дугаар хороонд (8,9,10 дугаар байрны тохижилт)



*Зураг 5.5.-5*

2. Баянгол дүүргийн 69 дүгээр байрны дунд



*Зураг 5.5.-6*

3. Баянгол дүүргийн 3 дугаар хороо (16 болон 45 дугаар байрны дунд иргэдийн амрах талбай, ногоон байгууламж, машины зогсоол)



*Зураг 5.5.-7*

4. Сонгинохайрхан дүүргийн 14,15,16 дугаар хороонд (Сагсан бөмбөгийн талбай 3х3 талбай, ногоон байгууламж)







*Зураг 5.5.-8*

Баянгол дүүргийн 1,3, Баянзүрх дүүргийн 11, Сүхбаатар дүүргийн 4,7, Хан-Уул дүүргийн 10, Чингэлтэй дүүргийн 6,16 дугаар хорооны заагдсан байршлуудад 3х3 сагсан бөмбөгийн талбай байгуулах, сандал хогийн сав байрлуулж, гэрэлтүүлэг суурилуулах ажлууд тус тус хийгдэж ашиглалтад орсон.



*Зураг 5.5.-9*

Нийслэлийн Засаг даргын захирамжаар иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх, аялж зугаалах газруудыг нэмэгдүүлэх, тэдгээрийг тохижуулах ажлууд хийгдэж буй. Энэ хүрээнд Дархан цаазат "Богдхан уул", "Туул гол"-ын эрэг дагуу байгалийн тэнцвэрт байдлыг хадгалах мөн ой мод, ургамалд сөрөг нөлөө үзүүлж буй байгууламжуудыг буулгах, байгальд ээлтэйгээр нийтийн зориулалтаар тохижуулах тохижилтын ажлууд хийгдэж байна.

*Тодруулбал:* Хан-Уул дүүргийн 22 дугаар хороо Ар зайсангийн гудамжнаас Дугуй цагаан хүртэлх уулын алхалтын замын алхах хэсэгт явган хүний зам талбайн тохижилт, амрах зугаалах хэсэгт сандал, сүүдрэвч, гадна тохижилтын тоноглол, амрах тохижилт, угтах хэсэгт үйлчилгээний байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, дугуйн зам, явган зам, авто зогсоол зэрэг тохижилтын ажлууд болон мод, зүлэг ногоон байгууламж нэмэгдүүлэх ажлууд тус тус хийгдэж нийтийн зориулалтаар тохижуулах тохижилтын ажил дуусч байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.



*Зураг 5.5.-10*

Мөн иргэдийн амьдрах орчинг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор орон сууцны хороолол дотор болон гэр хороолол дотор тохижилтын ажлууд хийгдэж, байнгын ашиглалтад оруулах комисс ажилласан төсөл арга хэмжээнээс дурьдвал:

*5.5.9.Гэр хороолол болон орон сууцны хороолол дунд тохижилт:*

Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, засвар шинэчлэлтийн ажил (Хан-Уул дүүрэг 9, 10, 16, 21 дүгээр хороо), гүйцэтгэгч Веллко инк ХХК



*Зураг 5.5.-11*

Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Баянзүрх дүүрэг 22 дугаар хороо, тохижилтын ажил, гүйцэтгэгч Шинэ хотын цамхаг ХХК



*Зураг 5.5.-12*

Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Баянзүрх дүүргийн 7 дугаар хороо, 10 дугаар байрны урд талд тохижилтын ажил. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тус ажлуудыг гүйцэтгэгч Онч тэнхлэг, Өлке констракшн ХХК



*Зураг 5.5.-13*

Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Бутээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил (Сонгинохайрхан дүүрэг 32, 35 дугаар хороо), гүйцэтгэгч Бат ахим аженси ХХК



*Зураг 5.5.-14*

Баянзүрх дүүргийн 1 дүгээр хорооны 26 дугаар байрны урд талд тохижилтын ажил, гүйцэтгэгч Люксдаймонд ХХК



*Зураг 5.5.-15*

*5.5.10.Мөн иргэдийн ая тухтай амьдрах, зорчих орчин нөхцлийг сайжруулах, нийтийн эзэмшлийн талбайг засаж тохижуулах зорилгоор атобусны буудлуудыг шинэчлэх, тохижилтын ажлууд хийгдэж байна.*

Баянзүрх дүүргийн 17 дугаар хорооны Да хүрээ захын шинэ автобусны буудлын угсралтын ажлыг Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэгч Болор МБ ХХК



*Зураг 5.5.-16*

Баянзүрх дүүргийн 4 дүгээр хорооны Эрүүл мэндийн 10 дугаар төв эмнэлгийн хойд талын тохижилтын ажил, гүйцэтгэгч Цагаан толгойн нуур ХХК.




*Зураг 5.5.-17*

*5.5.11.Их засварын ажил:*

Нийт 4.9 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 19 төсөл, арга хэмжээнд байнгын ашиглалтад оруулах комисс ажиллан хүлээлгэж өгөөд байна.

Баянзүрх дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн 2 дугаар байр, 3 дугаар хэлтэст гадна металл фасад, өрөө тасалгаа, коридор, хүлээлгийн хэсэгт тус тус хэсэгчилсэн дотор засал засвар шинэчлэлтийн ажлууд болон холбогдох тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажлууд хийгдэж дууссан. Дүүргийн хөрөнгө оруулалтаар тус ажлыг гүйцэтгэгч Мөнх Арвижих Ундарга ХХК,




*Зураг 5.5.-18*

Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо 20 дугаар цэцэрлэгийн бүлгийн болон багш нарын өрөө, коридор, ариун цэврийн өрөө, гал тогооны өрөөнүүдэд дотор засал, инженерийн шугам сүлжээ, агааржуулалтын зэрэг хэсэгчилсэн дотор засал, засвар шинэчлэлтийн ажлыг, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар тус ажлыг гүйцэтгэгч БИ КЭЙ БИ КОНСТРАКШН ХХК,






*Зураг 5.5.-19*

Нийслэлийн Засаг захиргааны 5 дугаар байрны 2 давхар Хүний нөөцийн хөгжлийн төвийн хурал, уулзалтын танхим, сургалт судалгааны танхим, кордорт шал, хана, таазны засвар шинэчлэлт хийгдэж тоног, төхөөрөмж суурилуулах ажил хийгдсэн.



*Зураг 5.5.-20*

Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн Эрт илрүүлэг үзлэг шинжилгээний тасаг, эрхлэгчийн өрөө, хурлын өрөө, ганцаарчилсан сургалтын өрөө, эмч нарын өрөөнүүдэд тус тус засвар шинэчлэлт хийгдсэн бөгөөд массажны сандал, буйдан, зурагт, хүүхдийн тоглоом, тариа эмчилгээний туслах хэрэгсэл, проктер зэрэг 31 нэр төрлийн 100 орчим тоног, төхөөрөмж

суурилуулах тохижилтын ажил хийгдэж дууссан. Тус ажлыг Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэгч Гурванбулаг Сод ХХК,



*Зураг 5.5.-21*

Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо 250 дугаар цэцэрлэгийн урлаг заал, арын хувцас солих өрөөнд засвар шинэчлэлт, тохижилтын ажил хийгдэж дууссан. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэгч “Залуу ноёд” ХХК,



*Зураг 5.5.-22*

Хан-Уул дүүргийн 8 цэцэрлэг, 6 сургуульд нийт 1861 ширхэг цонхны агаар шүүгч суурилуусан. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэгч “Дэлгэрэх” жимс ХХК,



*Зураг 5.5.-23*

Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо Ерөнхий боловсролын Амгалан цогцолбор сургуулийн барилгын фасад, дээвэр засвар дулаалгын ажил мөн сургуулийн бүх цонхыг солих, шинэчлэх, давцанг солих ажлууд хийгдэж дууссан. Нийслэлийн төсөв, Германы хамтын ажиллагааны хөрөнгө оруулалтаар гүйцэтгэгч “Цагаантолгойн нуур” ХХК

*5.5.12. Манай газраас ажлын хэсэг байгуулан, хүлээн авсан комиссын мэдээлэл:*

1. Орон сууцны 1 давхар, 150 ор (Хан-Уул дүүрэг, 11 дугаар хороо), гүйцэтгэгч иргэн А.Ганбаатар,

2. Цэцэрлэгийн байр, 100 ор (Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо), гүйцэтгэгч Хиллфорт ХХК,

3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нэг цэгийн төвийн тоног төхөөрөмж (Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 6 дугаар хороо) багц-3, гүйцэтгэгч Онцгой Өргөө ХХК,

4. Ухаалаг усан сан (Сонгино хайрхан дүүрэг, 31 дугаар хороо), гүйцэтгэгч Баялаг Говь ХХК,

5. Орон сууцны 1 давхар 75 ор (Баянзүрх дүүрэг, 5 дугаар хороо), гүйцэтгэгч иргэн А.Ганбаатар,

6. Биеийн тамир, спорт хорооны заалны шалыг будаж засварлах, сандал, шаардлагатай тоног төхөөрөмж (Багахангай дүүрэг, 1 дүгээр хороо), гүйцэтгэгч "Байтаг зүр хайрхан" ХХК,

7. Налайх дүүргийн 1-8 дугаар хороонд тохижилтын ажилд шаардлагатай материал худалдан авах, гүйцэтгэгч Эй би жи залаат ХХК,

8. Бие даасан барилга, 50 ор (Баянзүрх дүүрэг, 14 дүгээр хороо), иргэн Одхүү,

9. Бие даасан барилга, 150 ор (Баянзүрх дүүрэг, 23 дугаар хороо), иргэн Энхбат



*Зураг 5.5.-24*

### 5.6. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, судалгааны чиглэлээр

*5.6.1 2022 онд манай газраар хяналт тавин бүрэн хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын дүн шинжилгээ хийх, танилцуулга бэлтгэх*

Манай газарт 2022-2023 онд дамжин хэрэгжиж буй 474 ажил, 2022 онд бүрэн хэрэгжиж дууссан 275 ажлын мэдээллийг 43 үзүүлэлтээр дүн шинжилгээний хүснэгтийг боловсруулсан. Нийслэлийн 9 дүүрэгт 2022 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын дүн шинжилгээний хүснэгтэд тулгуурлан 18 хуудас бүхий танилцуулга бэлтгэж байна. Танилцуулгад дараах мэдээллийг багтаасан.

- Газрын танилцуулга
- Бодлогын бичиг баримт, хууль эрх зүйн үндэслэл
- 2023 онд батлагдсан хөрөнгө оруулалт
- 2022 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалт
- 2022-2023 онд дамжин хэрэгжиж буй Ажлын шалтгаан
- Хөрөнгө оруулалтын төлөвлөлт
- 2022 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээ
- Гүйцэтгэгчийн чадамж
- Худалдан авах ажиллагаа
- 2022 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалт, нитх-ын тойргоор
- Томоохон бүтээн байгуулалт
- 2022 онд бүрэн хэрэгжсэн хөрөнгө оруулалтын үр дүн, ач холбогдол



*График 5.6.-1*

### 5.6.2. Нийслэлд хэрэгжүүлэх боломжтой төслийг шинээр санаачлан боловсруулах

2022 онд 5 төсөл боловсруулагдаж, дүүрэг болон Нийслэлийн иргэдийн Төлөөдөгчдийн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлэн ажилласан. 2023 онд шинээр "Тархины цус харвалтын дараах нөхөн сэргээх сувилал байгуулах" төсөл боловсруулагдаж байна.

- Сургууль цэцэрлэгийн бүсэд тэмдэг тэмдэглэгээ хийх төсөл
- Цэцэрлэгийн эдэлбэр газарт стандарт тоглоом, мини сагсан бөмбөгийн талбай байгуулах
- Эко ногоон дээвэр
- Бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах
- Сүхбаатар дүүргийн орон сууцны хороололд оршин суудаг тулгуур эрхтний бэрхшээлтэй буюу тэргэнцэртэй иргэдийн амьдарч байгаа байрны орц, гарцыг стандартын дагуу засварлах төсөл "Сургууль цэцэрлэгийн бүсэд тэмдэг тэмдэглэгээ хийх төсөл" нь Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж байна.




*График 5.6.-2*

Нийслэлд тулгамдаж буй асуудлыг шийдэх, хэрэгжих боломжтой төслийг боловсруулж холбогдох газарт уламжлан хамтарч ажиллах боломжтой болсон.

### 5.6.3. Нийслэлийн 9 дүүргийн Тохижилт, гэрэлтүүлгийн судалгаа

Нийслэлийн 9 дүүргийн Тохижилт, гэрэлтүүлгийн судалгаа боловсруулах ажлын хүрээнд Тохижилт, гэрэлтүүлгийн судалгааны өнөөгийн байдал болон хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагын судалгааг google earth программд холболт хийж дуусгасан байна.

Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагын судалгаа болон хөрөнгө оруулалтын ажлуудын нэгдсэн мэдээллийн сан үүсэх бөгөөд судалгааны мэдээллийг тухайн салбарын хөрөнгө оруулалтыг жил бүр төлөвлөхөд ашиглана.

### 5.6.4. Хороодын хэрэгцээ шаардлагын судалгааг шинэчлэх

Нийслэлийн 9 дүүргийн 204 хороодын шинээр хуваагдсан газрын зургийг бэлтгэж 2 нүүр инфографик бүхий хороодын хэрэгцээ шаардлагын судалгааны мэдээллийг 2023 оны хүн ам, боловсролын статистик мэдээллээр шинэчилж байна.




*График 5.6.-3*

### 5.6.5. Нийслэлийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулах санал бэлтгэх, хүргүүлэх

Нийслэлийн 9 дүүрэгт хэрэгжүүлэх боломжтой зураг төсөв бэлэн 265.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 37 төсөл арга хэмжээний саналыг 3 хавсралтын дагуу боловсруулан 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 4/1968 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэв.

*Хүснэгт 5.6.-1. 2023 оны Хөгжлийн төлөвлөгөөнд хүргүүлсэн санал (дүүргээр)*

| № | Дүүрэг | Ажлын тоо | Төсөвт өртөг (тэрбум.төгрөг) |
|---|---|---|---|
| 1 | Сонгинохайрхан | 9 | 33,270.8 |
| 2 | Баянзүрх | 14 | 54,991.5 |
| 3 | Чингэлтэй | 1 | 685.0 |
| 4 | Хан-Уул | 5 | 42,712.4 |
| 5 | Сүхбаатар | 1 | 132.5 |
| 6 | Багануур | 3 | 12,553.8 |
| 7 | Налайх | 2 | 63,348.6 |
| 8 | Баянгол | 2 | 7,134.6 |
| 9 | Багахангай | 1 | 7,588.4 |
| **Нийт** | | **38** | **272,896.1** |



*Зураг 5.6.-4*

### 5.6.6. Улс, нийслэлийн 2024 оны төсвийн төсөлд тусгуулах санал бэлтгэх, хүргүүлэх

Нийслэлийн 9 дүүрэгт 2024 онд Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой зураг төсөв нь бэлэн барилга угсралтын 10 төсөл, арга хэмжээний саналын нэгтгэлийг Сангийн яамны 295 дугаар тушаалаар батлагдсан “Хамгийн бага зардлын шинжилгээ”, “Зардал үр ашгийн шинжилгээ” гэсэн загвар хүснэгтийн дагуу боловсруулж https://pimis.publicinvestment.gov.mn программд оруулсан бөгөөд Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд санал бэлтгэх, хүргүүлэх ажлын хүрээнд нийслэлийн 9 дүүрэгт хэрэгжүүлэх боломжтой зураг төсөв бэлэн 265.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 37 төсөл арга хэмжээний саналыг 3 хавсралтын дагуу боловсруулан 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 4/1968 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэв.

Зураг төсөв хийлгэх багц ажлын саналыг холбогдох дүрэм журмын дагуу боловсруулж хүргүүлэв.

*Хүснэгт 5.6-2. 2023 оны Улсын төсвийн төсөлд хүргүүлсэн санал (дүүргээр)*

| № | Дүүрэг | Ажлын тоо | Төсөвт өртөг (тэрбум.төг) |
|---|---|---|---|
| 1 | Сонгинохайрхан | 9 | 33,270.8 |
| 2 | Баянзүрх | 14 | 54,991.5 |
| 3 | Чингэлтэй | 1 | 685.0 |
| 4 | Хан-Уул | 5 | 42,712.4 |
| 5 | Сүхбаатар | 1 | 132.5 |
| 6 | Багануур | 3 | 12,553.8 |
| 7 | Налайх | 2 | 63,348.6 |
| 8 | Баянгол | 2 | 7,134.6 |
| 9 | Багахангай | 1 | 7,588.4 |
| **Нийт** | | **38** | **272,896.1** |

Улсын төсөвт хүргүүлсэн саналыг өмнөх үетэй харьцуулахад:




*График 5.6.-1*



*Зураг 5.6.-2*

### 5.6.7. Нийслэлийн боловсролын байгууллагуудын хүртээмж, шаардагдах хөрөнгө оруулалтын судалгааг шинэчлэх

Нийслэлийн боловсролын салбарын өнөөгийн байдлын судалгааг шинэчлэх, баяжуулах зорилгоор 2017 онд хийгдсэн Боловсролын салбарын судалгааг Нийслэлийн статистикийн газрын 2023 оны хүн амын статистик үзүүлэлт, Нийслэлийн Боловсролын газрын 2022-2023 оны хичээлийн жилийн статистик мэдээлэл болон Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраар хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын мэдээллээр сургуулийн өнөөгийн байдлын судалгааны 2023 оны тоон мэдээллээр шинэчилэв.

### 5.6.8. Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын хүртээмж, шаардагдах хөрөнгө оруулалтын судалгааг шинэчлэх

Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагуудын хүртээмж, шаардагдах хөрөнгө оруулалтын судалгааны мэдээллийг шинэчлэх зорилгоор Эрүүл мэндийн газраас гаргасан 2023 оны статистик мэдээлэлд үндэслэн 16-н хавсралтыг 15 үзүүлэлтээр шинэчилэв.

### 5.6.9. 2023 оны Барилгын голлох бараа материалын судалгаа

Барилгын голлох материалын үнийн өсөлтийг судлахдаа дараах байдлаар судалсан байна.

- Барилга.мн, барилгын материалын захууд, дотоод үйлдвэрлэгчид, импортлогчид гэх боломжит эх үүсвэрээр үнийн судалгааг 7 хоног бүр хийсэн.
- Барилга байгууламж, их засвар, тохижилт, инженерийн шугам сүлжээний ажилд голлох бараа материалын үнийн өсөлтийг нэг бүрчлэн гаргасан.
- Тайлант хугацаанд материалын үнийн өсөлтийн судалгааг 16 үзүүлэлтээр боловсруулан танилцуулга бэлтгэж удирдлагуудад 8 удаа танилцуулсан.




*Зураг 5.6.-3*

### 5.6.10. Газрын 2023 оны Бизнес төлөвлөгөө боловсруулах

Газрын стратеги, зорилго зорилтыг тодорхойлж, бүтэц зохион байгуулалт, үйлчилгээний шуурхай, найдвартай ажиллагаа, тэргүүлэгчдийн ур чадвар, ур ашгийг сайжруулах

1. 2023 оны орлогын тооцоолол гаргасан.
2. Бизнес төлөвлөгөөний дараах бүлгүүдийг нэгтгэн гаргасан.
   - Бизнес төлөвлөгөөний хураангуй
   - Санхүүгийн төлөвлөгөө
   - Орлогын төлөвлөгөө
   - Зардлын төлөвлөгөө
   - Зах зээлийн судалгаа, орчны шинжилгээ

- Менежментийн төлөвлөгөө
- Маркетингийн төлөвлөгөө




*Зураг 5.6.-4*

### 5.7. Хяналт шинжилгээ, үнэлгээний хорооны ажлын мэдээлэл

Тайлант хугацаанд Худалдаа авах ажиллагаа зохион байгуулагдсан Үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу нийт 59 гэрээ байгуулсан байна. Үүнд:

*Хүснэгт 5.7.-1. Үнэлгээний хорооноос ирүүлсэн зөвлөмжийг ажлын төрлөөр нь ангилбал:*

| Д/д | Ажлын төрөл | Ажлын тоо | Гэрээний үнийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Зурагтай | 10 | 25,726.2 |
| 2 | Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй | 29 | 73,007.8 |
| 3 | Зөвлөх үйлчилгээний ажил | 7 | 887.8 |
| 4 | Бараа худалдан авах | 13 | 419.4 |
| | **Нийт** | **59** | **100,041.4** |

*Хүснэгт 5.7.-2. Үнэлгээний хорооноос ирүүлсэн зөвлөмжийг хөрөнгийн эх үүсвэрээр ангилбал:*

| Д/д | Хөрөнгийн эх үүсвэр | Ажлын тоо | Гэрээний үнийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө | 34 | 5,590.6 |
| 2 | Нийслэлийн төсвийн хөрөнгө | 17 | 21,475.6 |
| 3 | Улсын төсвийн хөрөнгө | 8 | 72,975.2 |
| | **Нийт** | **59** | **100,041.4** |

2023 оны хагас жилийн байдлаар нийт 70 ажлын зөвлөмж ирүүлсэнээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д “Батлагдсан төсөл ,арга хэмжээний худалдан авах ажилгааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах” хугацаанд багтахгүй 11 зөвлөмжийг буцаасан.

### Дүгнэлт

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан хариуцлагын гэрээ, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр батлагдсан газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 99 хувьтай хэрэгжсэн байна.

### Цаашид авах арга хэмжээ

1. 2023 оны Эдийн засгийн зорилтот түвшингийн биелэлтийг хангаж ажиллах,
2. 2023-2024 оны өвөлжилтийг бэлтгэл ажлыг сайтар хангаж, инженерийн шугам, сүлжээний ажлуудыг эрчимжүүлж ажиллах,

3. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/490 дүгээр захирамжийн дагуу 40 байршилд 3*3 сагсан бөмбөгийн талбай байгуулах ажлыг эрчимжүүлж ажиллах, байнгын ашиглалтад хүлээлгэн өгөх,

4. Баянзүрх дүүргийн 11 -р хороо “Бага тэнгэрийн ам”, Хан-Уул дүүргийн Ар Зайсангийн гудамжнаас “Дугуй цагаан”-ны тохижилтын ажлуудыг комисс ажиллуулан хүлээлгэн өгч, тухайн орчны хог, хаягдлыг цэвэрлэх, тээвэрлэлтийг шуурхайлж ажиллах, баримт бичгийг өмчид шилжүүлэх,

5. Хөрөнгө оруулалт удааширсан, зогссон төсөл, арга хэмжээний жагсаалтыг гаргаж, зохион байгуулалтын ажил хэрэгжүүлэх,

6. Улс, нийслэл, гадаадын зээл тусламж болон бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний угсралт, тохижилтын ажлуудыг төлөвлөгдсөн графикт хугацаанд гүйцэтгүүлж, комисс ажиллуулан байнгын ашиглалтад оруулах, дулаан, цахилгааны дэд станц, гадна шугам сүлжээ, тоноглолын холбогдох бичиг баримтын бүрдлийг хангаж төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлж ажиллах,

7. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баримтыг барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл, төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгасан барилгын ажлын үе шатны хуваарийг үе шатны ажил нэг бүрээр тулган шалгаж, хянан баталгаажуулж, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэлийг буцааж залруулсанаар дахин хянаж баталгаажуулах,

8. Захиалагчийн техник хяналтын журмын төсөл боловсруулан, газрын даргаар батлуулах,

9. Иргэдтэй хийх уулзалтыг зохион байгуулах журмын төсөл боловсруулан, газрын даргаар батлуулах,

10. Сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулах журмын төсөл боловсруулан, газрын даргаар батлуулах,

11. Газрын нууцын журмын төсөл боловсруулан, газрын даргаар батлуулах.

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА Б.МӨНХБАТ

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА С.ЦЭДЭНСОДНОМ

БОЛОВСРУУЛСАН:
МЭРГЭЖИЛТЭН Б.ТҮВШИНЖАРГАЛ